МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ 2018-2025

Улаанбаатар хот
2018 он

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ШУА	Шинжлэх Ухааны Академи
SWOT	(Strengths, Weaknesses, Opportunities, Threats) Давуу тал, Сул тал, Боломж, Таагүй нөхцлийг тодорхойлох шинжилгээ
ЭША	Эрдэм Шинжилгээний Ажилтан
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
ШУАТГ	Шинжлэх Ухааны Академийн Тэргүүлэгчдийн Газар
ФТХ	Физик Технологийн Хүрээлэн
ПГХ	Палеонтологи, Геологийн Хүрээлэн
ГГЭХ	Газарзүй, Геоэкологийн Хүрээлэн
ООГХ	Одон Орон, Геофизикийн Хүрээлэн
ХХТХ	Хими, Химийн Технологийн Хүрээлэн
ЕСБХ	Ерөнхий болон Сорилын Биологийн Хүрээлэн
ХЗХ	Хэл Зохиолын Хүрээлэн
ТАХ	Түүх, Археологийн Хүрээлэн
ФХ	Философийн Хүрээлэн
ОУХХ	Олон Улсын Харилцааны Хүрээлэн
МАУА	Монголын Анагаах Ухааны Академи
ХААШУА	Хөдөө Аж Ахуйн Шинжлэх Ухааны Академи
ДХБ	Дотоод Харилцаатай Байгууллага
ГХБ	Гадаад Харилцаатай Байгууллага

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ …… 1

ХУРААНГУЙ …… 2

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: Шинжлэх ухааны Академийн хөгжлийн төлөв байдлын шинжилгээ, стратегийн чиглэл (SWOT) ……..…… 4

ХОЁРДУГААР БҮЛЭГ: Шинжлэх ухааны Академийн хөгжлийн стратегийн загвар …… 9

ГУРАВДУГААР БҮЛЭГ: Үйл ажиллагааны зорилтууд…… 10

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: Үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжүүлэх үе шат …… 12

ТАВДУГААР БҮЛЭГ: Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэгчдийн үйл ажиллагааны уялдаа холбоо…… 26

ЗУРГААДУГААР БҮЛЭГ: Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэр …… 31

ДОЛООДУГААР БҮЛЭГ: Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга зам ……..…… 36

НАЙМДУГААР БҮЛЭГ: Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт…… 38

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ: Стратеги төлөвлөгөөний удирдлага, үнэлгээ. ..…… 45

ХАВСРАЛТУУД

Хавсралт-1. ШУА-ийн түүхэн хөгжил, бүтэц зохион байгуулалт …… 46

Хавсралт-2. ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийн эрдэм шинжилгээний ажилтны тоо, бүрэлдэхүүн…… 50

Хавсралт-3. ШУА-ийн олон улсын түвшинд танигдсан бүтээл туурвил …… 52

Хавсралт-4. ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийн санхүүжилт, судалгааны орчин…… 53

Хавсралт-5. ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийн эрдэм шинжилгээний ажилтнуудын насны байдал, сарын дундаж цалин …… 55

Хавсралт-6. ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийн барилга байгууламж, лабораторийн төлөв байдал ……..…… 56

Хавсралт -7. ШУА-ийн Эрхэм зорилгын нэр томъёоны тайлбар …… 57

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 11 сарын 21 өдөр Дугаар 16 Улаанбаатар хот

ШУА-ийн дунд хугацааны (2018-2025) стратеги
төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт
оруулах тухай

Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 2, 7, 10 дугаар зүйл, ШУА-ийн дүрмийн 2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн "Стратеги төлөвлөгөөний мониторингийн зөвлөл"-өөс гаргасан санал, дүгнэлтийг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1. ШУА-ийн дунд хугацааны (2018-2025) стратеги төлөвлөгөөнд тэргүүлэгч гишүүдийн гаргасан саналыг тусган хавсралт ёсоор нэмэлт өөрчлөлт оруулсугай.

2. ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийн дунд хугацааны (2018-2025) стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээний тайланг гарган 2023 оны I улиралд багтаан Тэргүүлэгчдийн газарт ирүүлэхийг хүрээлэнгийн захирлуудад даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ, АКАДЕМИЧ Д.РЭГДЭЛ

ЭРДЭМТЭН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА, АКАДЕМИЧ Б.АВИД

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 26-өдөр Дугаар 02 Улаанбаатар хот

ШУА-ийн дунд хугацааны (2018-2025) стратеги төлөвлөгөө батлах тухай

Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 2, 7, 10 дугаар зүйл, ШУА-ийн дүрмийн 2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1. ШУА-ийн дунд хугацааны (2018-2025) стратеги төлөвлөгөөг тэргүүлэгч гишүүдийн саналыг тусган хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг үр дүнтэй шуурхай зохион байгуулж ажиллахыг ШУА-ийн дэд ерөнхийлөгч (Г.Чулуунбаатар, Б.Баярт), Эрдэмтэн нарийн бичгийн дарга (Б.Авид), Орлогч дарга (Б.Бат-Эрдэнэ) нарт үүрэг болгосугай.

3. Стратеги төлөвлөгөөний мониторингийн зөвлөл байгуулж ажиллуулахыг ШУА-ийн ерөнхийлөгч (Д.Рэгдэл)-д даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ Д.РЭГДЭЛ

ЭРДЭМТЭН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.АВИД

ӨМНӨХ ҮГ

Аливаа улс орны хөгжлийн тулгуур үндэс, хөтөч залуур нь шинжлэх ухаан технологи болох нь өндөр хөгжилтэй орны түүхэн замналаар ч, үсрэнгүй хөгжсөн орнуудын туршлагаар ч нэгэнт нотлогдсон зүйл билээ. Тийм ч учраас хөгжлийн бодлогын хэтийн төлвийг тодорхойлохдоо шинжлэх ухаан, технологийн хөгжлийг тэргүүлэх чиглэл болгон дэвшүүлдэг болжээ. Орчин үед энэ хандлага хэзээ, хэзээнээс чухалчилагдаж байна.

Ойрын болон дунд хугацаанд хүн төрөлхтний хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдэхийн тулд Нэгдсэн үндэсний байгууллага “Даян дэлхийн тогтвортой хөгжил -2030” -ыг баталлаа. Манай улсын парламент 2016 онд “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030”-ыг, Монгол улсын Засгийн газар 2017 онд “Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого”-оо шинэчлэн батлаад байна. Монгол улсын Шинжлэх ухааны Академи дэлхийн хөгжлийн чиг хандлага, улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн байгууллагын хувьд бэхжин хөгжих дунд хугацааны стратегийн төлөвлөгөөгөө боловсруулаа.

Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн дунд хугацааны стратегийн төлөвлөгөө \2018-2025\-ний гол зорилт нь байгууллагын менежментийг бүхэлд нь боловсронгуй болгох, үйл ажилагааны чадавхийг бэхжүүлэн үр өгөөжийг сайжруулах, шинээр үүсч буй асуудлыг хэтийн зорилго, чиглэлдээ нийцүүлэн оновчтой шийдэхэд чиглэж байгаа болно.

Энэхүү стратеги төлөвлөгөө нь бидний хийж ирсэн ажлын ололт, амжилтыг дүгнэсэн, цаашид байгууллагын үйл ажиллагааны эрхэм зорилгыг алсын хараа, хэтийн зорилгодоо чиглүүлэн эрдмийн хамт олныхоо эрхэмлэх ёс зүй, үнэт зүйлээ чандлан сахиж ажиллах таатай орчин, шаардлагатай чадамжийг бүрдүүлэхэд чиглэсэн бидний олон талт үйл ажиллагааны удидамжийн баримт бичиг, дунд хугацааны хөтөлбөр болон хэрэгжих болно.

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ЕРӨНХИЙЛӨГЧ, АКАДЕМИЧ Д.РЭГДЭЛ

ХУРААНГУЙ

Монгол Улсын Шинжлэх ухааны Академи бол судалгаа, боловсруулалтын ажлыг үндэсний хэмжээнд нэгтгэн зохион байгуулах чиг үүрэг бүхий төрийн харьяаллын шинжлэх ухааны төв байгууллага юм. Тус Академи нь үндэсний шинжлэх ухааны чадавхийг улсын хөгжлийн гол хөшүүрэг болгон авч явах, нийгмээ соён гэгээрүүлэх, засгийн газарт зөвлөх байх, зорилтуудыг Их, Бага чуулган, харьяа эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтнуудынхаа үйл ажиллагаанд удирдлага болгон ажилладаг .

Аливаа тогтолцоо, тодорхой байгууллагын оршин тогтнож, тогтвортой хөгжих үндэс нь үйл ажиллагаагаа алсын болон дунд, ойрын ирээдүйд төлөвлөн, бодлого зорилтоо тодорхойлох явдал мөн. Иймэ төлөвлөлтийн үндсэн нэг хэлбэр нь дунд хугацааны стратегийн төлөвлөгөө юм.

Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030, Шинжлэх ухаан технологийн талаар төрөөс баримтлах бодлого болон харьяа хүрээлэнгүүдийн стратегийн төлөвлөгөө, ШУА-ийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээг үндэс болгон “Монгол Улсын шинжлэх ухааны Академийн стратегийн төлөвлөгөө (2018-2025)”-г боловсруулав.

Стратегийн төлөвлөгөөнд ШУА-ийн алсын хараа “**Шинжлэх ухаан, технологи, инновацд тулгуурласан нийгэм-эдийн засгийн хөгжлийн түүчээ байх**” гэж, эрхэм зорилгыг “**Олон улсад нэр хүндтэй, өрсөлдөх чадвартай, шинжлэх ухаан, технологийн үндэсний төв байгууллага болох**” хэмээн тодорхойлов.

Шинжлэх ухааны Академийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг:

- Монгол Улсад суурь шинжлэх ухааны үндсэн салбаруудыг тогтвортой хөгжүүлэх, технологийн тэргүүлэх чиглэлүүдийн судалгааг хошуучлах;
- Монгол Улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн харилцааны хөгжил, өрсөлдөх чадварын төлөв байдалд шинжлэх ухааны үүднээс дүгнэлт гаргаж, цаашдын чиглэл, арга замыг тодорхойлсон үндэслэл боловсруулах;
- Үндэсний шинжлэх ухаан технологийн салбарын мониторингийг тогтмолжуулж, салбарын хөгжлийн бодлогын суурь болон шинэчлэлийн асуудлаар засгийн газарт зөвлөмж хүргэх ажлыг хэвшүүлэх;
- Үндэсний шинжлэх ухааны чадавхийг бэхжүүлэх, нийгмийг соён гэгээрүүлэх;
- Шинжлэх ухаан, технологийн хөтөлбөр, төсөлд үнэлгээ өгөх, хянан магадлагаа хийх;
- Эрдмийн зэрэгтэй боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх явдал гэж үзлээ.

Стратегийн төлөвлөгөөнд 2018-2025 онд ШУА, харъяа хүрээлэнгүүдийн хамт үндэсний тэргүүлэх эрдмийн байгууллагын сүлжээнээс олон улсын эрдмийн сүлжээнд өрсөлдөх чадвар бүхий тогтолцоо болох зорилтыг дараах дөрвөн багцад нэгтгэн тодорхойлов. Үүнд:

1. Шинжлэх ухааны академийн менежментийн чадавхийг бэхжүүлж, хүний нөөцийг хөгжүүлэн, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлнэ.

- ШУА-ийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг шинэчлэн бүрдүүлэхэд тухай бүр санаачилгатай оролцох, хуульд нийцүүлэн дүрэм журмыг цаг алдалгүй шинэчлэх;
- Удирдлагын оновчтой бүтэц, зохион байгуулалт, үр нөлөө бүхий уян хатан тогтолцоог бүрдүүлэх;
- Оюуны хөдөлмөр, эрдэм шинжилгээний ажлын чанарын үнэлгээний стандартыг байгууллагын хөгжлийн шалгуур болгон хэрэгжүүлэх;

- Хүний нөөцийн хөгжлийг үе шаттай бэхжүүлж, өөрийгөө идэвхжүүлэлтийг дэмжин, ажлын чанар, үр дүнгийн үнэлгээнд суурилсан цалин, урамшууллын системийг нэвтрүүлэх.

2. Олон эх үүсвэр бүхий санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэн судалгаа боловсруулалтын ажлын таатай орчин бүрдүүлнэ.

- Олон эх үүсвэр бүхий санхүүжилтийн тогтолцоонд шилжих эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Дотоодын нийт бүтээгдэхүүнд шинжлэх ухаан, технологийн салбарын төсвийн санхүүжилтийн эзлэх хувийг нэмэгдүүлэх талаар хуулийн хүрээнд идэвхтэй ажиллах;
- Олон улсын стандартад нийцсэн лабораторийн баазыг бэхжүүлэх нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Хүрээлэн-хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх бүхий л хэлбэрийн захиалгат судалгаа, боловсруулалтын үйл ажиллагааг нэмэгдүүлэх;
- Төр-хувийн хэвшлийн оролцоотой Инновацийг дэмжих хуримтлалын сан бүрдүүлэх;
- Судалгаанд мэдээллийн технологийн орчин үеийн дэвшлийг хэрэглэх дэд бүтцийн сүлжээ бүрдүүлэн хөгжүүлэх;
- Төсвийн санхүүжилт, гадаадын төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд судалгааны лабораторийн тоног төхөөрөмжийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх.

3. Шинжлэх ухаан технологийн тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлж, гадаад харилцаа, хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэн, судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулна.

- Шинжлэх ухаан, технологи, инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлж, хүч, хөрөнгийг төвлөрүүлэх;
- Институци хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг хамтран тодорхойлж, шийдвэрлэдэг болгох;
- Олон улсын болон гадаадын байгууллагатай хамтран ажиллах бодлого зохицуулалтын үйл ажиллагааг оновчлон, төсөл хөтөлбөрийн тоо, санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх;
- Шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр олон улсын байгууллагууд дахь гишүүнчлэлээ нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх;
- Олон улсын нэр хүндтэй эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлүүлэх судалгааны өгүүллийн тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн урамшууллын тогтолцоог бий болгох;
- Монгол орны эрдэс баялаг, түүхий эдийн нөөцөд түшиглэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дэвшилтэт технологийг нутагшуулах чиглэлээр идэвхи санаачлагатай ажиллах.

4. Инновацын орчин, соёлыг төлөвшүүлж, судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг нийгэмд түгээн, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг дээшлүүлнэ.

- Судалгаа боловсруулалт ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэнд оруулах чадавх бүхий инновацын тогтолцоог ШУА-ийн системийн түвшинд бүрдүүлэх;
- Хүүхэд, залуучуудын шинжлэх ухааны сэтгэлгээг төлөвшүүлэх үйл ажиллагааг холбогдох байгууллагатай хамтран хөгжүүлэх;
- ”Энтрепренёр эрдэмтэн” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- Судалгаа боловсруулалт, инновацын үр дүнг хэрэглэгчдэд түгээх, борлуулах сүлжээ бүрдүүлэн ажиллуулах;
- Оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг сайжруулж, оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах механизм бий болгох;
- Нийгэмд шинжлэх ухааны үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ, СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ

1.1. Хөгжлийн төлөв байдлын шинжилгээ

Хөгжлийн дотоод хүчин зүйлс (Байгууллагын зүгээс удирдан жолоодох боломжтой хүчин зүйлс)**:**	
S – Давуу тал:	**W – Сул тал:**
• Үндэсний болон олон улсын хэмжээнд танигдсан, нэр хүндтэй, олон жилийн түүхтэй, тогтвортой бүтэц, зохион байгуулалт бүхий орчин цагийн шинжлэх ухааны ууган байгууллага (Хавсралт 1). • Салбар бүрийн эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтны туршлага чадварыг нэгтгэсэн хүний нөөцтэй, гадаадын олон арван эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажилладаг, бодлого, үйл ажиллагааны залгамж чанар бүхий нэр хүндтэй байгууллага (Хавсралт-2). • Гадаад улс орон, бүс нутаг, дэлхийд танигдсан бүтээл туурвил ихтэй, Монгол Улсын хэмжээнд эрдэм шинжилгээний бүтээлийн 1/3 хувийг дангаар хийж гүйцэтгэдэг, оюуны өндөр чадамжтай эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтантай (Хавсралт 3). • Улсын хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх болон хөгжлийн бодлого тодорхойлоход эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтны үүрэг, оролцоо өсөн нэмэгдэж буй бөгөөд нийгмийг соён гэгээрүүлэх зохих туршлагатай. • Улсын төсвийн санхүүжилттэй, судалгаа, шинжилгээний ажлын зохих орчин, нөөцтэй (Хавсралт 4).	• “ШУА-ийн эрх зүйн байдлын тухай” хуульд эрх зүйн байдал болон чиг үүрэг, зохион байгуулалтын шинжтэй зохицуулалт зарим талаар бүрхэг. • Үйл ажиллагааны менежментэд Их, дээд сургууль, хувийн хэвшил, иргэний нийгмийн хэлбэрээр ажилладаг эрдэм шинжилгээний байгууллагуудтай харьцаж ажиллах механизм бүрэн зүгшрээгүй. • Санхүүжилтийн нэг эх үүсвэртэй, хямрах эрсдэл өндөртэй, хүрэлцээ муутай. • Шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээлтэй холбоотойгоор эрдэм шинжилгээний ажилтны хөдөлмөрийн үнэлэмж буурч, энэ нь тус салбарын хүний нөөцийн чадавхи сулрахад нөлөөлсөн (Хавсралт 5). • Лабораторийн техник, тоног төхөөрөмжийн хангамж, шинэчлэлийн түвшин дэлхийн жишгээс доогуур, үүнд чиглэгдсэн хөрөнгө оруулалт хязгаарлагдмал учраас олон улсын түвшинд хүрсэн судалгааны лаборатори дутмаг (Хавсралт 6). • Зарим хүрээлэнгийн барилга, байгууламж нь хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй болсон. • Гадаад, дотоодын шинжлэх ухааны байгуулагуудтай хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулан ажилладаг ч энэ тэнцүү хамтран ажиллах санхүүгийн болон хүний нөөцийн боломж хязгаарлагдмал, гадны төсөл, хөтөлбөрт хамрагдах чадвар харьцангуй сул.

	• Судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх явц удаан, инновацийг дэмжих санхүүгийн нөөцгүй, эрдэмтэн-энтрэпренёр ховор, судалгааны үр дүнг үйлдвэрлэл, бизнест дамжуулах дэд бүтэцгүй, үйлдвэрлэлд нэвтэрч байгаа патент, технологийн тоо цөөн.
Хөгжлийн гадаад хүчин зүйлс (Байгууллагын зүгээс удирдан чиглүүлэх боломжгүй хүчин зүйлс)**:**	
О – Боломж (Таатай нөхцөл):	**Т – Аюул занал (Таагүй нөхцөл):**
• Үйл ажиллагаа нь бие даасан хуулиар зохицуулагдсан үндэсний статустай. • Шинжлэх ухаан технологийн салбарыг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчин зохих хэмжээнд бүрдсэн. • Төр засгийн зүгээс шинжлэх ухаан технологийн салбарыг дэмжих талаар эерэг хандлага бий болж байгаа. • Төрийн бодлого боловсруулах үйл ажиллагаанд академийн Ерөнхийлөгч, Тэргүүлэгчид, Академичид, Их, Бага чуулганы гишүүд оролцох боломж хуулиар нээлттэй. • ШУА-ийн хэмжээнд цахим засаглалыг хэрэгжүүлэх дэд бүтэц, технологийн суурь боломж бүрдсэн. • Хувийн хэвшил дэх шинэ мэдлэг, технологи эрэлхийлэх хандлага өсөн нэмэгдэж байгаа. • Инновацын ерөнхий эрх зүйн орчин бүрдсэн. • Шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр гадаад харилцаа сайтай.	• Шинжлэх ухааны байгууллагад хандах төр, засгийн бодлого, хандлага, дэмжлэг тогтворгүй, тууштай бус. • Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэхэд чиглэгдсэн төрийн санхүүжилт хангалгүй. • ШУА нь төрийн бус байгууллага тул тэр зарчмаар ажиллах ёстой гэсэн байр суурь баримталдаг улс төрчид цөөн боловч бий. • Судалгаа, боловсруулалтын ажлын төсөвт хүний нөөцийг хөгжүүлэх зардал тусгагддаггүй, магистр, докторын зэргийн сургалтын чанар хангалтгүй. • Эрдэм шинжилгээний хүрээлэн дээр магистр, докторын зэргийн сургалт явуулах эрхзүйн боломжгүй. • Асуудалд мухар сүсэг, далдын хүч, ид шидээр тайлбар өгдөг бөө, хувилгаан, ид шидтэн их. Тэдэнд итгэж даган баясагчид эрс нэмэгдсэн. • Инновацын хууль хэрэгжүүлэх дагалдах журмууд бүрэн гараагүй. • Инновацийг дэмжих сан, дотоодын венч сан байхгүй. • Шинжлэх ухаан, технологийн парк болон үйлдвэрлэлийн кластерийн хөгжил сул. • Үйлдвэрлэл, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагаа сул. • Эрдэм шинжилгээний ажилтны цалин, Их сургуулийн ижил түвшний багш нарын цалингаас 2.5 дахин бага.

	• Нэг сая хүнд ноогдох эрдэм шинжилгээний ажилтны тоогоор Азийн дунджаас 3 дахин бага, хүний нөөц хязгаарлагдмал. • Технологийн үйлдвэрлэл явуулдаг компани бараг байхгүй учраас гаргасан технологи үйлдвэрт нэвтрэх боломж хомс.

Тайлбар. *Хавсралт 1. ШУА-ийн түүхэн хөгжил, бүтэц зохион байгуулалт*
Хавсралт 2. ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийн эрдэм шинжилгээний ажилтны тоо, бүрэлдэхүүн
Хавсралт 3. ШУА-ийн олон улсын түвшинд танигдсан бүтээл туурвил
Хавсралт 4. ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийн санхүүжилт, судалгааны орчин
Хавсралт 5. ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийн эрдэм шинжилгээний ажилтнуудын насны байдал, сарын дундаж цалин
Хавсралт 6. ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийн барилга байгууламж, лабораторийн төлөв байдал

1.2. Богино, дунд, урт хугацааны стратегийн чиглэл

SO - ШУА-ийн давуу талд тулгуурлан + гадаад орчны таатай боломжийг сайн ашиглах БОГИНО ХУГАЦААНЫ СТРАТЕГИ:	**WO - ШУА-ийн сул талыг бууруулан + гадаад орчны таатай боломжийг сайн ашиглах ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ:**
• Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар үйл ажиллагааны эрх зүйн илүү таатай орчин бүрдүүлэх; • Шинжлэх ухаан, технологийн салбарт зарцуулах хөрөнгийн хэмжээг 5 дахин нэмэгдүүлэх төрийн бодлогыг үе шаттай хэрэгжүүлэх талаар тодорхой санаачилга гаргаж ажиллах; • Шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэхэд гадаад хамтын ажиллагааг ашиглах; • ШУА, эрдэм шинжилгээний байгууллагын оновчтой бүтэц бүрдүүлэн үйл ажиллагааны өгөөжийг нэмэгдүүлэх;	• ШУА-ийн үйл ажиллагаагтогтвортой, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэгдсэн менежмент, маркетингийн цогц бодлого боловсруулан хэрэгжүүлэх замаар төр, олон нийтийн дунд нэр хүндийг нь дээшлүүлэх; • Инновацийг дэмжих, гарааны компаний чадавхийг дээшлүүлэх, төр-эрдэм шинжилгээ-бизнесийн байгууллагын түншлэлийг бэхжүүлэх замаар санхүүжилтийн олон эх үүсвэрт шилжих; • Үндэсний эрдэмтэн судлаачдын бий болгосон шинэ бүтээл, технологийг бойжуулж, инновацын бүтээгдэхүүн болгох инкубатор төвүүдийг бий болгож бэхжүүлэх; • Хэрэгжүүлсэн захиалгат төсөл, хувийн хэвшлийн судалгаа, боловсруулалтын ажлын орлогоос эрдэм шинжилгээний ажилтны нэмэлтээр цалинжих механизм бүрдүүлж хэрэгжүүлэх;

• Нийгэм, эдийн засаг, байгаль орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх болон хөгжлийн бодлого боловсруулахад эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтны оролцоо, оюуны нөөцийг төвлөрүүлэх менежментийг төгөлдөржүүлэх; • Менежментийн чадавхид суурилсан удирдлагын тогтолцоонд шилжих нөхцөл бүрдүүлэх; • Эрдэм шинжилгээний болон удирдах ажилтныг бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлэх; • Ажлын үнэлгээний стандартыг боловсруулж, оюуны хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх, цалингийн сүлжээгүй болох; • Уламжлалт харилцаатай БНХАУ, ОХУ болон бусад улс орнуудтай хамтарсан судалгааны лаборатори, төвүүдийг байгуулах, эрдэмтдийг урт, богино хугацаагаар солилцон ажиллуулах; • Олон улсын нэр хүндтэй эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд хэвлүүлэх өгүүллийн тоог нэмэгдүүлэх хөшүүрэг, урамшууллын тогтолцоог бий болгох.	• Улс орны хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн их сургууль, эрдэм шинжилгээ, төрийн байгууллагуудын үр дүнтэй хамтын ажиллагааг хангахад манлайлагчийн үүрэг гүйцэтгэх; • Хүрээлэнгүүдийн лаборатори, барилга, байгууламжийг шинэчлэхэд дотоодын хөрөнгө оруулалт, гадаадын төсөл хөтөлбөрийг төвлөрүүлэх; • Хүний нөөцийн тоо, чанарын үзүүлэлтээр Ази тивийн дундаж төвшинд хүрэх; • Эрдэм шинжилгээний ажилтны цалин, орлогыг төрийн өмчийн их сургуулийн багш нарын цалингийн жишигт хүргэх; • Гадаад харилцааны шугамаар байгуулсан гэрээ, хэлэлцээр, санамж бичгүүдэд цогц үнэлэлт өгч, үр дүнг дээшлүүлэх.
ST- ШУА-ийн давуу талд тулгуурлан + гадаад орчны таагүй нөхцлийн сөрөг нөлөөг арилгах ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ:	**WT- Гадаад орчны таагүй нөхцөлд ШУА-ийн сул талаа бууруулах замаар гарах сөрөг үр дагаварыг аль болох багасгах УРТ ХУГАЦААНЫ СТРАТЕГИ:**
• Судалгаа, боловсруулалтын ажлын үр өгөөжийг дээшлүүлэх; • Шинээр бүрдэх хууль эрх зүйн орчны хүрээнд ШУА-ийг үндэсний статус бүхий шинжлэх ухаан, технологийн төв болгон бэхжүүлэх; • Шинжлэх ухаан технологийн салбарт хуваарилагдах төрийн санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллах;	• Парламент болон шийдвэр гаргах төвшинд лобби бүлэг ажиллуулж, ШУА-ийн тогтвортой, үр өгөөжтэй ажиллах эрхзүйн орчин нөхцлийг бүрдүүлэх; • Шинжлэх ухааны байгууллага-бизнесийн сүлжээг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлж, санхүүжилтийн шинэ эх үүсвэртэй болох;

• Шинжлэх ухааны үндэсний чадавхийг бэхжүүлэх талаар бие даасан хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх; • Менежментийн чадавхид суурилсан удирдлагын тогтолцоо, зохион байгуулалтын зохистой бүтцийг бүрдүүлэн, үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэх; • Эрдэмтэн солилцооны хөтөлбөрийг өргөтгөх; • Зүүн болон Төв Азийн шинжлэх ухаан, технологи, инновацын төрөлжсөн судалгааны салбар нэгжийг эх орондоо байгуулах замаар өөрийн орны шинжлэх ухаан, технологи, инновацын байгууллага, эрдэмтэн, судлаачдын нэр хүндийг өргөх, мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх.	• ШУА-д Магистр, докторын сургалт, судалгааны хөтөлбөр хэрэгжүүлэх, ахисан төвшиний сургууль байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлж хэрэгжүүлэх; • Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны залгамж халааг бэлтгэх талаар тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх; • Бүс нутгийн шинжлэх ухааны академиудын сүлжээнд эзлэх байр суууриа бэхжүүлэх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН ЗАГВАР

Алсын хараа

Шинжлэх ухаан технологи, инновацад тулгуурласан нийгэм-эдийн засгийн хөгжлийн түүчээ байгууллага байх

Эрхэм зорилго

Олон улсад нэр хүндтэй, өрсөлдөх чадвартай шинжлэх ухаан технологийн үндэсний төв байгууллага байх

Үнэт зүйлс

- **Мэдлэгт суурилсан эдийн засгаас тогтвортой хөгжилд оруулах хувь нэмэр**
- **Эрдэм шинжилгээний ажилтны нийгмийн хариуцлага, академик эрх чөлөө, ёс зүй, эх ороонч-зөв төлөвшилд суурилсан шинжлэх ухаан технологийн үйл ажиллагаа**
- **Бүтээлч сэтгэлгээ, эерэг хандлага, хөрвөх чадвартай эрдмийн эвсэг хамт олны төлөвшил**

СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУД

I. **Шинжлэх ухааны Академийн менежментийн чадавхыг бэхжүүлэх**
II. **Шинжлэх ухаан технологийн тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлж, судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг нийгэмд түгээн дэлгэрүүлэх**
III. **Хүний нөөцийг хөгжүүлж, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх**
IV. **Судалгаа боловсруулалтын таатай орчин бүрдүүлэн хөгжүүлэх**
V. **Олон эх үүсвэр бүхий санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх**
VI. **Инновацийн орчин, соёлыг төлөвшүүлж, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх**
VII. **Гадаад харилцаа, хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх**

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТУУД

№	Стратегийн зорилтууд	Үйл ажиллагааны зорилтууд
I	Шинжлэх ухааны Академийн менежментийн чадавхийг бэхжүүлэх	1.1. Эрх зүйн орчныг шинэчлэн бүрдүүлж, үйл ажиллагааны цар хүрээг тэлэх
		1.2. Менежментийн чадавхид суурилсан удирдлагын тогтолцоо, үр ашиг бүхий бүтэц, зохион байгуулалтыг бүрдүүлэх
		1.3. Ажлын чанарын үнэлгээний стандартыг байгууллагын хөгжлийн шалгуур болгон хэрэгжүүлэх
II	Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлж, судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг нийгэмд түгээн дэлгэрүүлэх	2.1. Суурь судалгаа, технологи, инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлж хэрэгжүүлэх
		2.2. Онолын судалгааны түвшинг дээшлүүлж, шинэ мэдлэг бий болгох үйл явцыг дэмжих
		2.3. Хэрэглээний судалгааны чанарыг сайжруулж, тэргүүлэх чиглэлээр шинэ технологи хөгжүүлэх
		2.4. Монгол Улсын хөгжлийн бодлого тодорхойлох, хэрэгжүүлэхэд манлайлан оролцох
		2.5. Хүүхэд, залуучуудын шинжлэх ухааны сэтгэлгээг төлөвшүүлэх зорилтыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх
		2.6. Монголын шинжлэх ухааны ололтыг түгээн сурталчлах зорилтыг дотоод, гадаадын шинжлэх ухаан, боловсролын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх
		2.7. ШУА, түүний харьяа байгууллагуудаас эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийн чанарыг олон улсын жишигт хүргэх, хөгжүүлэх
		2.8. Эрдэмтдийн бүтээлийн чанарыг сайжруулж, импакт фактор бүхий сэтгүүлд нийтлүүлэх тоог нэмэгдүүлэх
III	Хүний нөөцийг хөгжүүлж, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх	3.1. “Чадварлаг эрдэмтэн” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх
		3.2. Эрдэм шинжилгээний ажилтны мэдлэг, чадвар, бүтээлийг үнэлэх шалгуурыг шинэчлэн тогтоож, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх
		3.3. Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны ажиллаж, амьдрах нөхцөл, хангамжийг сайжруулах
		3.4. Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх
IV	Судалгаа боловсруулалтын таатай орчин бүрдүүлэн хөгжүүлэх	4.1. Лабораторийн баазыг олон улсын жишигт нийцүүлэн бэхжүүлэх
		4.2. Шинжлэх ухааны хамтарсан парк байгуулан хөгжүүлэх
		4.3. Орчин үеийн шаардлагад нийцсэн эрдэм шинжилгээний бие даасан номын сан байгуулах
		4.4. Мэдээллийн технологийн орчин үеийн дэвшлийг ашиглах дэд бүтцийн сүлжээ бүрдүүлэн хөгжүүлэх

		4.5. Хүрээлэнгүүдийн барилга, байгууламжийг шинэчлэх, өргөтгөх
V	Олон эх үүсвэр бүхий санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх	5.1. Олон эх үүсвэр бүхий санхүүжилтийн тогтолцоонд шилжих эрх зүйн орчныг бүрдүүлэх
		5.2. Шинжлэх ухаан, технологийн салбарын төсвийн санхүүжилтийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн нэмэгдсэн хэмжээнд дүйцүүлж ШУА-ийн санхүүжилтийн хэмжээг өсгөх
		5.3. Хүрээлэн-хувийн хэвшлийн түншлэлийг өргөтгөж, судалгаа, боловсруулалт, инновацын үйл ажиллагааг дэмжин санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх
		5.4. Томоохон зорилтыг шийдвэрлэхэд гадаадын төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг төвлөрүүлэх
VI	Инновацын орчин соёлыг төлөвшүүлж, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх	6.1. Судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэнд оруулах инновацын тогтолцоог байгууллагын түвшинд бүрдүүлэх
		6.2. “Энтрепренёр эрдэмтэн” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх
		6.3. Оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг сайжруулж, оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах
		6.4. Институци хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг хамтран шийдвэрлэх
VII	Гадаад харилцаа, хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх	7.1. Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын урьдчилсан бэлтгэлийг хангах, хэрэгжүүлэх зорилтонд гадаад хамтын ажиллагааг төвлөрүүлэх
		7.2. Шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр олон улсын байгууллагуудад элсэх гишүүнчлэлээ нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх
		7.3. Олон улсын байгууллагатай хамтран ажиллах бодлого зохицуулалтын үйл ажиллагааг оновчлон, төсөл хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх
		7.4. Уламжлалт харилцаатай БНХАУ, ОХУ болон бусад улсын шинжлэх ухааны болон дээд боловсролын байгууллагатай бүс нутгийн хөгжлийн тулгамдсан асуудлаар шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагаагаа өргөжүүлэх
		7.5. Эрдэм шинжилгээний ажилтныг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх чиглэлээр олон улсын нэр хүндтэй их сургууль, шинжлэх ухааны байгууллагатай хамтарсан эрдэмтэн солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Үйл ажиллагааны зорилтууд	Хэрэгжүүлэх төлөвлөгөөт арга хэмжээ	Үе шат	
		I шат: 2018-2021	II шат: 2022-2025
I стратеги зорилт: ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ			
1.1.Эрх зүйн орчныг шинэчлэн бүрдүүлж, үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлэх	1.1.1. ”Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж хууль санаачлагчдад өргөн барих	+	
	1.1.2. Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал боловсруулж тусгуулах	+	
	1.1.3. Инновацын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал боловсруулж тусгуулах	+	
	1.1.4. Шинжлэх ухаан технологийн төсөл хэрэгжүүлэх журмын шинэчлэн найруулсан төсөлд санал бэлтгэж тусгуулах	+	
	1.1.5. Шинжлэх ухаан технологийн үйл ажиллагаатай холбоотой бусад эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулахад санаачилгатай оролцох	+	+
	1.1.6. ШУА-ийн хөдөлмөрийн дотоод журам болон бусад дүрэм, журмыг иж бүрэн шинэчлэн мөрдөж ажиллах	+	
	1.1.7. Инновацын үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх, үүрэг бүхий бүтцийн нэгжийг байгуулан ажиллуулах	+	
	1.1.8. Төрийн захиргааны болон их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах шинэлэг арга замыг бүрдүүлэн ажиллах	+	+
	1.1.9. Орон нутаг, хувийн хэвшлийн байгууллагатай тогтоосон хамтын ажиллагааг өргөжүүлэх	+	+
	1.1.10. Олон улсын мэргэжлийн байгууллагын гишүүнчлэлийн санхүүжилтийг бүрдүүлэх, төсөвт суулгах, үйл ажиллагаанд идэвхтэй		

	байгууллагуудтай гэрээ хэлэлцээр байгуулах механизмыг сайжруулах	+	+
	1.1.11.Гадаадын их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын залуучуудыг ШУА-ийн ахисан түвшний болон мэргэжил дээшлүүлэх сургалт, судалгааны төсөл, хөтөлбөрт хамруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх	+	+
	1.1.12. Хэвлэл, мэдээллийн байгууллага, олон нийтийн мэдээллийн сүлжээнд бий болгосон харилцаагаа бэхжүүлж, шинжлэх ухаан технологийг сурталчлах ажлыг шинэ шатанд гаргах	+	+
1.2.Менежментийн чадавхад суурилсан үр ашиг бүхий бүтэц, зохион байгуулалтыг бүрдүүлэх	1.2.1. Салбарын бүх байгууллагын хэмжээнд менежментийн чадавхын үнэлгээ хийж, сайжруулах чиглэлийг тогтоох	+	
	1.2.2. ШУА-ийн бүтэц, зохион байгуулалтын оновчтой хэлбэрийг бүрдүүлэх	+	
	1.2.3. Төлөвлөлт, зохион байгуулалт, хяналтын нэгдмэл системтэй болох	+	+
	1.2.4. Байгууллагын менежментийн чадавхыг бэхжүүлэх сургалтын хөтөлбөртэй болж, тодорхой давтамжтай зохион байгуулах	+	+
1.3.Ажлын чанарын үнэлгээний стандартыг байгууллагын хөгжлийн шалгуур болгон хэрэгжүүлэх	1.3.1.Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ-үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулж мөрдөж ажиллах	+	+
	1.3.2.Салбарын бүх байгууллагын хэмжээнд мөрдөх чанарын удирдлагын нэгдсэн стандартыг боловсруулж хэрэгжүүлэх	+	+
	1.3.3.Ажлын чанар, үр дүнгийн үнэлгээнд суурилсан цалин, урамшууллын системийг нэвтрүүлэх	+	+
II стратеги зорилт: ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙГ ШИНЭЧЛЭН ТОДОРХОЙЛЖ, СУДАЛГАА БОЛОВСРУУЛАЛТЫН АЖЛЫН ҮР ДҮНГ НИЙГЭМД ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ			
2.1.Шинжлэх ухаан, технологи, инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлж хэрэгжүүлэх	2.1.1. Эдийн засгийн бүтээмж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн шинжлэх ухаан технологийн тэргүүлэх чиглэлүүдийг шинэчлэн тодорхойлж хөгжүүлэх	+	+

	2.1.2. Аж үйлдвэрийн 4 дэх хувьсгалын хөгжилд нийцсэн шинжлэх ухаан, технологийн шинэ чиг хандлагыг хөгжүүлэхэд судалгааны ажлыг төвлөрүүлэх	+	+
	2.1.3. Био, ногоон, ухаалаг технологийн судалгааг хөгжүүлэх	+	+
	2.1.4. Үр өгөөжтэй инновацын бүтээгдэхүүнийг үйлдвэрлэл, хэрэглээ бий болгох санаачилгыг дэмжих	+	+
	2.1.5. Үндэсний инновацын тогтолцооны гол оролцогч талуудтай хамтран Инновацын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	+	+
2.2. Онолын судалгааны түвшнийг дээшлүүлж, шинэ мэдлэг бий болгох үйл явцыг дэмжих	2.2.1. Шинжлэх ухааны салбар дундын онолын суурь судалгааг хөгжүүлэхэд чиглэгдсэн эрдэмтдийн хамтын ажиллагааг дэмжих	+	+
	2.2.2. Тэргүүлэх чиглэлд багтах онолын суурь судалгаанд гадаадын эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтдийн хамтын ажиллагааг түлхүү чиглүүлэх	+	+
	2.2.3. ШУА-иас гадаадын эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулиудад ажиллаж буй эрдэмтдийн судалгааг гаргаж, тэднийг судалгааны төсөл, хөтөлбөрт хамруулах эрх зүйн орчныг бий болгох	+	+
	2.2.4. Унаган байгаль, амьтан, ургамал, байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглахад чиглэсэн онолын судалгааг хөгжүүлэх	+	+
	2.2.5. Үндэсний түүх, соёл, оюуны бүтээлийн нийгмийн үнэ цэнийг тодорхойлон хөгжүүлэхэд чиглэгдсэн нийгэм хүмүүнлэгийн онолын судалгааг хөгжүүлэх	+	+
	2.2.6. Онолын суурь судалгааны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх	+	+
2.3. Хэрэглээний судалгааны чанарыг сайжруулж, тэргүүлэх чиглэлээр шинэ технологи хөгжүүлэх	2.3.1. Монгол Улсын хөгжлийн стратеги болон бизнесийн эрэлтэд нийцсэн, эх орны түүхий эдийн нөөц дээр түшиглэсэн хэрэглээний судалгааг хөгжүүлэх	+	+

	2.3.2 .Экспортын чиг баримжаатай, өрсөлдөх чадвар бүхий инновацын бүтээгдэхүүн бий болгоход чиглэгдсэн хэрэглээний судалгааг түлхүү дэмжих	+	+
	2.3.3. Импорт орлох, бусад орнуудад үр дүнтэй болох нь нотлогдсон дэвшилтэт технологийг нутагшуулан үйлдвэрлэлд нэвтрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх	+	+
	2.3.4. Тэргүүлэх чиглэлээр туршилтын үйлдвэр байгуулах, түүнд түшиглэсэн дунд түвшний төслүүдийг хэрэгжүүлэх	+	+
2.4. Монгол Улсын хөгжлийн бодлого тодорхойлох, хэрэгжүүлэхэд манлайлан оролцох	2.4.1“Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтууд, тэдгээрийн хэрэгжилтийг хангах шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах	+	+
	2.4.2. Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, хүн амын нутагшил, суурьшлын хэтийн хандлагыг шинэчлэн тогтооход эрдэмтэд, судлаачдыг зохион байгуулж оролцуулах	+	+
	2.4.3. Нийгэм-эдийн засгийн салбар бүрийн хөгжлийн бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах талаар төрийн захиргааны төв байгууллагуудтай нягт хамтран ажиллах	+	+
	2.4.4. Үндэсний тэргүүлэх компаниудын судалгаа боловсруулалтын ажилтай үйл ажиллагаагаа уялдуулан ажиллах	+	+
2.5. Хүүхэд, залуучуудын шинжлэх ухааны сэтгэлгээг төлөвшүүлэх зорилтыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	2.5.1. Хүүхэд, залуучуудын дунд шинжлэх ухаан технологийн хөгжил, дэвшлийг сурталчлан тайлбарлах үйл ажиллагааг зохион байгуулах	+	+
	2.5.2. Ертөнцийн үүсэл, хөгжил, хүрээлэн буй орчны хувьсал, амьдралд тохиолдох үзэгдэл юмсын талаар эрдэмтдийн цуврал лекц зохион байгуулах	+	+
	2.5.3. Шинжлэх ухаан танин мэдэхүйн чиглэлээр богино хэмжээний кино хийж, нийтийн хүртээл болгох	+	+
	2.5.4. Шинжлэх ухааны сонирхолтой чиглэлээр хүүхэд, залуусын дунд төрөл бүрийн уралдаан тэмцээн, хэлэлцүүлэг тогтмол зохион байгуулах	+	+
	2.5.5. Шинжлэх ухаанд суурилсан хүүхдийн насны онцлогт тохирсон зураг хуудас, хялбаршуулсан ном хэвлэн хүртээл болгох	+	+

2.6. Монголын шинжлэх ухааны ололтыг сурталчлах зорилтыг дотоод, гадаадын шинжлэх ухаан, боловсролын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	2.6.1.Судалгаа, боловсруулалтын ажлын үр дүнгээр нээлттэй өдөрлөг зохион байгуулах	+	+
	2.6.2. Шинжлэх ухааныг нийгэмд таниулах зорилго бүхий мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлдэг мэргэжлийн клубуудыг байгуулан, үйл ажиллагааг дэмжин ажиллуулах	+	+
	2.6.3. Монголын шинжлэх ухаан, технологийн ололт амжилтыг олон улсын түвшинд сурталчлах ажлыг ШУА-ийн гадаад гишүүд, хүндэт докторууд болон хамтын ажиллагаатай байгууллагуудтай хамтран зохион байгуулах	+	+
	2.6.4. Шинжлэх ухаан, техник технологийн хөгжил, ололт амжилтыг сурталчилсан, нийгмийг соён гэгээрүүлэхэд чиглэсэн шилдэг бүтээлийн шагналыг жилд нэг удаа “Шинжлэх ухааны ажилтны өдөр” - өөр олгодог байх	+	+
2.7.ШУА-ийн харьяа байгууллагуудаас эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний сэтгүүлийн чанарыг олон улсын жишигт хүргэх, хөгжүүлэх	2.7.1. Эрдэм шинжилгээний сэтгүүлийг хэвлэн нийтлэхэд тавигдах олон улсын (JPPS) шаардлагад нийцүүлж шинэчлэн, хөгжүүлэх”	+	+
	2.7.2. Сэтгүүлийн өгүүлэлд хөндлөнгийн, хараат бус хянан магадалгаа хийх мэргэжлийн хэвлэлийн зөвлөлийг салбар шинжлэх ухаан бүрээр байгуулан ажиллуулах	+	+
	2.7.3. Сонгож авсан сэтгүүлүүдийг импакт фактор бүхий сэтгүүл болгон хөгжүүлэх	+	+
2.8. Эрдэмтдийн бүтээлийн чанарыг сайжруулж, импакт фактор бүхий сэтгүүлд нийтлүүлэх тоог нэмэгдүүлэх	2.8.1. Бүх судлаачдын эрдэм шинжилгээний өгүүлэлд импакт фактор бүхий сэтгүүлийн шаардлагыг тавьж, чанарыг жигд сайжруулах	+	+
	2.8.2. Гадаадын импакт фактор бүхий сэтгүүлүүдтэй холбоо тогтоож, хамтран ажиллах	+	+
	2.8.3. Импакт фактор бүхий сэтгүүлд нийтлүүлсэн өгүүллийн тоог судлаачдын ажлыг үнэлэх нэг шалгуур үзүүлэлт болгон авч үзэх	+	+

III стратеги зорилт: ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЖ, ХӨДӨЛМӨРИЙН ҮНЭЛЭМЖИЙГ НЬ ДЭЭШЛҮҮЛЭХ			
3.1.”Чадварлаг эрдэмтэн” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	3.1.1. Их, дээд сургуулийн III ангиас эхлэн судалгааны ажилд авьяас чадвартай, хүсэл сонирхолтой оюутнуудыг сонгон авч гэрээ байгуулж эрдэмтдийн залуу халааг бэлтгэх	+	+
	3.1.2. Эрдэм шинжилгээний залуу ажилтныг шинжлэх ухаан технологийн тэргүүлэх чиглэлийн ба ахисан түвшний сургалтад хамруулах, ШУА-ийн хүрээлэнгүүдийн томоохон лабораторид түшиглэсэн ахисан түвшний \ магистрантур, докторантур\ сургууль байгуулах	+	+
	3.1.3.Эрдэмтэнсолилцооныхөтөлбөрийг өргөжүүлж, мэргэжил нэгт гадаадын эрдэмтдийг “Зочин профессор”-оор урьж, залуу эрдэм шинжилгээний ажилтнуудыг дагалдуулан ажиллуулах	+	+
	3.1.4. Гадаадын өндөр хөгжилтэй оронд суралцах эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны тоог нэмэгдүүлэх	+	+
	3.1.5. Гадаадын төсөл, хөтөлбөрт хамрагдах эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны эзлэх хувийг нэмэгдүүлэх	+	+
	3.1.6 ШУА-н салбарын эрдэм шинжилгээний ажилтны тоог нэмэгдүүлж, чадавхжуулах, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, үйл ажиллагааны цар хүрээг тэлэх	+	+
3.2. Эрдэм шинжилгээний ажилтны мэдлэг, чадвар, бүтээлийг үнэлэх шалгуурыг шинэчлэн тогтоож, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх	3.2.1. Эрдэм шинжилгээний ажилтанд тавигдах шаардлага, шалгуурыг шинэчлэн тодорхойлж баталгаажуулан, мөрдөж ажиллах		
	3.2.2. Дотоод, гадаадад мэргэжил эзэмшсэн чадварлаг эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтныг ШУА-д татан ажиллуулах нөхцөл бололцоогоор хангах		
	3.2.3. Үр бүтээлтэй ажиллаж буй залуу эрдэм шинжилгээний ажилтны гадаадын докторантурт элсэн суралцахад нь дэмжлэг үзүүлэх		

	3.2.4. Залуу эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтанд олгох судалгааны грант, докторын дараах судалгааны тэтгэлгийн тоог нэмэгдүүлэх	+	+
	3.2.5. Харьяа хүрээлэнгүүдийн эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтныг судалгааны үр дүнгээ олон улсын сэтгүүлд хэвлүүлэхэд зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх	+	+
	3.2.6. Олон улсын хурал, зөвлөгөөн, сургалтад эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтныг тэдний мэргэжлийн болон судалгааны тэргүүлэх чиглэл, ажлын үр дүнг үндэс болгон оролцуулж байх санхүүжилтийн хөшүүргийг бий болгох	+	+
	3.2.7. Эрдэм шинжилгээний ажилтны цалингийн сүлжээг дээшлүүлэх, зэрэг дэвийг нэмэгдүүлэх асуудлыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх	+	+
	3.2.8. Эрдэм шинжилгээний ажилтнуудын төсвийн гадуурх гэрээт судалгаа, боловсруулалтын ажлыг дэмжиж, орлогоор нь урамшуулах хөшүүрэг бий болгох	+	+
3.3. Эрдэм шинжилгээний ажилтнуудын ажиллаж, амьдрах нөхцөл хангамжийг сайжруулах	3.3.1. Байгууллагын захиалгын орон сууцаар эрдэм шинжилгээний ажилтнуудыг хангах ажлыг зохион байгуулах	+	+
	3.3.2. ШУА-ийн харьяа зуслангийн газартай болж эрдэм шинжилгээний ажилтнуудыг хамруулах	+	+
	3.3.3. ШУА-иас их, дээд сургуулиудын ахисан түвшний сургалтад хичээл заах, магистр, докторын ажил удирдах эрдэм шинжилгээний ажилтнуудын тоог нэмэгдүүлэх	+	+
	3.3.4. Мэдлэгийн менежментийг хэрэгжүүлж, ЭША-ийг мэргэшүүлэх, давтан сургах, чадавхжуулах, мэдлэгээ хуваалцах, хамтран ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх х	+	+
	3.3.5. Ажилтны хөдөлмөр, нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр тогтмол үйл ажиллагаа эрхлэх хүний нөөцийн орон тоо бий болгох	+	+

3.4. Эрдэм шинжилгээний ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх	3.4.1. Эрдэм шинжилгээний ажилтанд тавигдах мэргэжлийн ёс зүйн шаардлагыг шинэчлэн тодорхойлох	+	+
	3.4.2. Эрдэм шинжилгээний ажилтны мэргэжлийн ёс зүйн журмыг боловсруулж баталгаажуулан мөрдөж ажиллах	+	+
IV стратеги зорилт: СУДАЛГАА БОЛОВСРУУЛАЛТЫН ТААТАЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ			
4.1. Лабораторийн баазыг олон улсын жишигт нийцүүлэн бэхжүүлэх	4.1.1. Томоохон хүрээлэнгүүдийн дэргэд орчин үеийн шаардлага хангасан тэргүүлэх чиглэлийн лаборатори 4-ийг байгуулах: - Түүх, археологийн музей, судалгааны цогцолбор төв, түүхийн үнэт олдвор, дурсгалт судалгааны өвийг хадгалах, хамгаалах цаг уурын бичил орчин бүхий агуулах, нөхөн сэргээх лабораторийн цогцолбор - ШУА-ийн тооцооллын төв - Судалгааны нэгдсэн лаборатори - Биологийн идэвхт бэлдмэл туршилтын цехийг бэхжүүлж өргөтгөх	+	+
	4.1.2. Гадаадын төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд хүрээлэнгүүдийн 10 лабораторийн тоног төхөөрөмжийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх, өргөтгөх	+	+
	4.1.3. Салбар дундын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор дотоодын эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулиудтай хамтран “дундын ашиглалтын лаборатори” байгуулан хамтран ашиглах	+	+
4.2. Шинжлэх ухааны хамтарсан парк байгуулан хөгжүүлэх	4.2.1. Зүүн болон Төв Азийн шинжлэх ухаан, технологи, инновацын төрөлжсөн парк байгуулж, эрдэм шинжилгээний ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, судалгааны үр дүнг дээшлүүлэх нөхцөл бүрдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах	+	+
4.3. Орчин үеийн шаардлагад нийцсэн эрдэм шинжилгээний бие даасан номын сан байгуулах	4.3.1. ШУА-ийн дэргэд стандарт шаардлагад нийцсэн нэгдсэн номын сантай болох	+	+
	4.3.2. Нэгдсэн номын санд орчин үеийн цахим технологийг иж бүрэн нэвтрүүлэх	+	+

	4.3.3. Олон улсын өндөр зэрэглэлтэй мэргэжлийн ном, сэтгүүлийн хангамж, ашиглалтыг сайжруулах	+	+
	4.3.4. Ахмад эрдэмтдийн номын хандивыг идэвхжүүлэх замаар номын санг баяжуулах	+	
	4.3.5. Орчин үеийн технологи бүхий хэвлэлийн үйлдвэртэй болох	+	+
4.4. Мэдээллийн технологийн орчин үеийн дэвшлийг ашиглах дэд бүтцийн сүлжээ бүрдүүлэн хөгжүүлэх	4.4.1. Суперкомпьютер бүхий тооцооллын төвд өгөгдөхүүний тооцоолол (симуляц, их өгөгдөл) бүхий судалгаа шинжилгээг хөгжүүлэх, улмаар өгөгдлийн хуримтлал, хадгалалтын төвлөрсөн банк бий болгох	+	+
	4.4.2. ШУА-ийн болон харьяа хүрээлэнгүүдийн дотоод сүлжээ ашиглалтыг тогтмолжуулах, интернэтийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	+	+
	4.4.3. Мэдээлэл технологийн орчин үеийн дэвшилд тулгуурлан судалгаа боловсруулалт хийх арга зүйг эрдэм шинжилгээний ажилтнуудад эзэмшүүлэх сургалт тогтмол зохион байгуулах	+	+
4.5. Хүрээлэнгүүдийн барилга, байгууламжийг шинэчлэх, өргөтгөх	4.5.1. Дараах барилга, байгууламжийг шинээр барьж ашиглалтад оруулна - Палеонтологийн судалгааны төв, музейн барилга - Ургамал, амьтны генийн фондын барилга -Түүх, археологийн судалгааны төв, музейн цогцолбор	+	+
	4.5.2. Дараах байруудыг өргөтгөн тохижуулна: -Палеонтологи геологийн хүрээлэнгийн лабораторийн өргөтгөлийн барилга - Ботаникийн цэцэрлэгийн бүтээн байгуулалт, өргөтгөл - Орон нутаг дахь судалгааны нэгжүүдийн өргөтгөл - Физик, технологийн хүрээлэнгийн барилгын хүзүүвчийн өргөтгөл	+	+
	4.5.3. Хүрээлэнгүүдийн байр ашиглалтыг сайжруулах, нэгдсэн захиргаа байгуулах	+	+
	4.5.4. Гадаадын хамтарсан судалгааны төсөл хэрэгжүүлэгч судлаачдад түр ажиллаж, амьдрах таатай нөхцөл бүрдүүлэх	+	+

V стратеги зорилт: ОЛОН ЭХ ҮҮСВЭР БҮХИЙ САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХ			
5.1.Олон эх үүсвэр бүхий санхүүжилтийн тогтолцоонд шилжих эрх зүйн орчныг бүрдүүлэх	5.1.1. Шинжлэх ухааны байгууллагын санхүүгийн бие даасан байдлыг өргөжүүлэхтэй холбоотой санал боловсруулж, хуулийн төсөлд тусгуулах	+	+
	5.1.2. Судалгааны лабораторийн зориулалттай тоног төхөөрөмж, урвалжийг холбогдох татвараас чөлөөлөх, хөнгөлөх санал боловсруулж хуулийн төсөлд тусгуулах	+	+
	5.1.3. Эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийг суурь санхүүжилттэй болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх	+	+
5.2. Шинжлэх ухаан, технологийн салбарын төсвийн санхүүжилтийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн нэмэгдсэн хэмжээнд дүйцүүлж ШУА-ийн санхүүжилтийн хэмжээг өсгөх	5.2.1.”Төрөөс Шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого”-т тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад ойлгуулж дэмжлэг авах	+	+
	5.2.2. Шинжлэх ухаан, технологийн салбарын төсвийн санхүүжилтийн хувь хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг холбогдох хуульд тусгуулан хэрэгжүүлэх	+	+
	5.2.3 Шинжлэх ухааны Академид улсын төсвөөс олгодог санхүүжилтийн хэмжээг ДНБ-ий 1.5 хувьд хүргэх	+	+
5.3. Хүрээлэн-хувийн хэвшлийн түншлэлийг өргөтгөж, судалгаа, боловсруулалт, инновацын үйл ажиллагааг дэмжин санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх	5.3.1. Гарааны компаниудын үйл ажиллагааг дэмжиж, оюуны өмч, патент технологийг эдийн засгийн эргэлтэд оруулж, орлогын эх үүсвэр бүрдүүлэх	+	+
	5.3.2. Гарааны компаниудын бизнесийг урт хугацаатай, хүү багатай зээлээр дэмжих эрх зүйн орчин бүрдүүлэх	+	+
	5.3.3. Судалгаа боловсруулалт, инновацын үйл ажиллагаанд төр-хувийн хэвшил, бусад санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх	+	+
5.4. Томоохон зорилтыг шийдвэрлэхэд гадаадын төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг төвлөрүүлэх	5.4.1. Хамтын ажиллагаатай гадаад түншүүдийн санхүүжилтийг стратегийн төлөвлөлттэй томоохон лаборатори, парк байгуулахад чиглүүлэх менежментийн бодлого баримтлах	+	+
	5.4.2. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр шинээр лаборатори байгуулах, шинэчлэх, эрдэм шинжилгээний ажилтнуудыг бэлтгэх	+	+

	5.4.3. Хүрээлэнгүүдийн гадаадтай хамтарсан, төсөл, хөтөлбөр, санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх	+	+
	5.4.4. Томоохон мега төслүүдэд ШУТ-ийн үйл ажиллагааны санхүүжилтийг тусгах механизмыг бүрдүүлэх	+	+
VI стратеги зорилт: ИННОВАЦЫН ОРЧИН, СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЖ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ			
6.1.Судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах, инновацын тогтолцоог байгууллагын түвшинд бүрдүүлэх	6.1.1. ШУА-ийн дэргэд Инновац хөгжлийн төв байгуулан ажиллуулах	+	+
	6.1.2. Инновац хөгжлийн төв нь хүрээлэнгүүдийг хувийн хэвшил-бизнесийн үйл ажиллагаатай холбох гүүр болж ажиллах	+	+
	6.1.3. Дундын оффис байгуулан эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтан-энтрепренёрууд хамтарч ажиллах, ирээдүйн хөрөнгө оруулагч, түншлэгч, салбар бүрийн инженер технологийн мэргэжилтнүүд, ментор, зөвлөхүүдтэй танилцах, хүрээгээ тэлэх боломж олгох арга хэмжээг тогтмол зохион байгуулах	+	+
	6.1.4. Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтан -энтрепренёрын шилдэг төсөл шалгаруулах журам боловсруулж хэрэгжүүлэх	+	+
	6.1.5. ШУА-ийн хүрээнд технологи дамжуулах соёлыг төлөвшүүлж, эзэмшиж буй оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах, орлого хуваарилах цогц арга замыг бүрдүүлэх	+	+
	6.1.6. Шинжлэх ухаан, технологи, инновацын нээлттэй өдөрлөг зохион байгуулах	+	+
6.2. ”Энтрепренёр эрдэмтэн” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	6.2.1. Хүрээлэнгүүдээс төсөл хэрэгжүүлэх, манлайлах авьяас чадвартай, технологи дамжуулал, оюуны өмчийн эрхийн хамгаалал, гарааны бизнес, инновацын үйл ажиллагаанд оролцох хүсэл сонирхолтой эрдэм шинжилгээний ажилтнуудыг сонгон авч тусгай хөтөлбөр болон ахисан түвшний сургалтад хамруулах	+	+
	6.2.2. Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтныг дотоод, гадаадын инноваци, энтрепренёрын мэдлэг, чадвар олгох сургалтад хамруулахад дэмжлэг үзүүлэх	+	+

	6.2.3. Зочин профессорын солилцооны хөтөлбөрт “Энтрепренёр эрдэмтэн” солилцох төсөл хэрэгжүүлэх, залуу эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтныг туршлагажуулах	+	+
	6.2.4. Шалгарсан энтрепренёр эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтан төсөл, хөтөлбөр чөлөөтэй хэрэгжүүлэх эрхзүйн орчин, нөхцөлийг бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх, мөн дотоод, гадаадын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, оролцох нөхцөл боломжийг бүрдүүлэх	+	+
	6.2.5. Шалгарсан энтрепренёр эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтныг их, дээд сургуульд хичээл заах, магистр, докторын ажил удирдахыг дэмжих, мэдлэгээ хуваалцах, хамтран ажиллахыг урамшуулах	+	+
6.3. Оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг сайжруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах	6.3.1. Оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг оновчтой зохион байгуулах эрх зүйн орчныг сайжруулах	+	+
	6.3.2. Салбарын эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны оюуны өмчийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж хэрэглээнд оруулах	+	+
	6.3.3. Салбарын эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны оюуны өмч, технологи дамжуулах талаарх мэдлэг, чадварыг дээшлүүлж, оюуны өмчийн бүтээлийг үнэлэх чадавх бүрдүүлж хэрэгжүүлэх	+	+
	6.3.4. Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны оюуны өмчийг үр өгөөжтэй ашиглах, борлуулах дэд бүтэц, механизмыг оролцогч талуудтай хамтран бүрдүүлж хэрэгжүүлэх	+	+
6.4. Институци хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг хамтран шийдвэрлэх	6.4.1. Олон улсын болоод дотоодын хамтын ажиллагаанд түшиглэн хувийн хэвшилтэй хамтран технологи шингээсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	+	+
	6.4.2. Монгол орны эрдэс баялаг, түүхий эдийн нөөцөд түшиглэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд чиглэгдсэн дэвшилтэт технологийг нутагшуулахад талуудын оролцоо, түншлэлийг дэмжин хөгжүүлэх	+	+

	6.4.3. Технологи дамжуулах төв, бизнес инкубатор зэрэг инновацын дэд бүтцийг хувийн хэвшилтэй хамтран байгуулах	+	+
	6.4.4. Үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэгцээтэй судалгааны ажлын үр дүнг харилцан ашигтай нэвтрүүлэх, хамтран эзэмших нөхцөлийг бүрдүүлэх	+	+
	6.4.5. Гарааны компани байгуулах, хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг бүх талаар дэмжих	+	+
	6.4.6. Магистр, докторын сургалт, судалгааны хөтөлбөрийг холбогдох их сургуультай хамтран хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлж ажиллах	+	+
VII стратеги зорилт: ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЦАР ХҮРЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ			
7.1. Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын урьдчилсан бэлтгэлийг хангах, хэрэгжүүлэх зорилтод гадаад хамтын ажиллагааг төвлөрүүлэх	7.1.1. Монгол Улсад хэрэгжүүлэх боломжтой Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын гол чиглэлийг судлан тогтоох	+	+
	7.1.2. Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын гол чиглэлийн дагуу хамтран ажиллах гадаад орнуудын байгууллагуудтай гэрээ байгуулах	+	+
	7.1.3. Гадаадын түнш байгууллагуудад Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын гол чиглэлээр ШУА-ийн нэр дээр мэргэжилтэн-судлаач суралцуулж, залуу боловсон хүчин бэлтгэх	+	+
	7.1.4. Гадаад түншүүдтэй хамтран Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын гол чиглэлээр шинэ технологи нэвтрүүлэх	+	+
7.2. Шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр олон улсын байгууллагуудтай хийх гишүүнчлэлээ нэмэгдүүлж үйл ажиллагаагаа өргөжүүлэх	7.2.1. Олон улсын нэр хүндтэй 5-аас доошгүй байгууллагад гишүүнээр элсэж, гэрээ, хэлэлцээр байгуулж хамтран ажиллах	+	+
	7.2.2. Олон улсын болон бүсийн хуралдаан, зөвлөгөөнийг Монгол Улсад зохион байгуулах санаачилга гарган ажиллах	+	+
7.3. Олон улсын байгууллагатай хамтран ажиллах бодлого зохицуулалтын үйл ажиллагааг оновчлон, төсөл хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх	7.3.1. Хамтарсан төслүүдийн санал боловсруулах шалгаруулалтад оролцох судалгааны байгууллага, эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтныг олон улсын болзол, шаардлагад нийцүүлэн чиг зорилготой бэлтгэх тогтолцоо бий болгох	+	+

	7.3.2. Гадаадтай хамтарсан төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих “Хамтарсан төсөл хэрэгжүүлэх, урамшуулах” төрөлжсөн сан байгуулан ажиллуулах	+	+
7.4. Уламжлалт харилцаатай БНХАУ, ОХУ-ын шинжлэх ухааны болон дээд боловсролын байгууллагатай бүс нутгийн хөгжлийн тулгамдсан асуудлаар шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааг өргөжүүлэх	7.4.1. ОХУ, БНХАУ-ын ШУА-ын хүрээлэнгүүдтэй шууд хамтын ажиллагааг нэгдсэн бодлого, гэрээ, хэлэлцээрийн хүрээнд дэмжин хамтарсан судалгааны лабораториудыг байгуулах	+	+
	7.4.2. Хээрийн судалгааны хамтарсан экспедицийн удирдлага, зохион байгуулалт, үр дүнг сайжруулах,	+	+
	7.4.3. Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжил, байгаль орчныг хамгаалах чиглэлээр хөрш хоёр орны шинжлэх ухааны байгууллагуудтай гурван талын, хоёр талын хамтарсан судалгааны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	+	+
	7.4.4. Эдийн засгийн коридорын төсөл хөтөлбөрт ШУА-ийн оролцоог нэмэгдүүлэх	+	+
7.5. Эрдэм шинжилгээний ажилтнуудыг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх чиглэлээр олон улсын нэр хүндтэй их сургууль, шинжлэх ухааны байгууллагатай хамтарсан эрдэмтэн солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх	7.5.1. Гадаадад мэргэжил дээшлүүлэх талаар эрдэм шинжилгээний ажилтнуудын дунд сургалт зохион байгуулах	+	+
	7.5.2. Гадаадын магистрантур, докторантурт суралцах элсэгчдийн бэлтгэлийг хангах, гадаад хэлний сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	+	+
	7.5.3. Эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтнууд нарын дипломын дараах сургалтыг дэмжих төрөлжсөн сан байгуулах	+	+
	7.5.4. Олон улсын болон гадаад орнуудын нэр хүндтэй байгууллагуудын эрдэмтэн солилцооны хөтөлбөрт эрдэм шинжилгээний ажилтнуудыг оролцуулах	+	+

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УЯЛДАА ХОЛБОО

Үйл ажиллагааны зорилтууд		Хэрэгжүүлэгч байгууллагууд																		
	ШУА ТГ	Харьяа хүрээлэн															Салбар академи		ДХБ	ГХБ
		ФТХ	МТТХ	ХҮ	ГХ	ГТХ	ООХ	ХХТХ	БХ	БЦХ	ХЗХ	АХ	ТУЗХ	ФХ	ОУСХ	ТИ	ТССХ	МАУА	ХААШУА		
I Стратегийн зорилт: ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ																					
1.1. Эрх зүйн орчныг шинэчлэн бүрдүүлж, үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлэх																					
1.2. Менежментийн чадавхад суурилсан үр ашиг бүхий бүтэц, зохион байгуулалтыг бүрдүүлэх																					
1.3. Ажлын чанарын үнэлгээний стандартыг байгууллагын хөгжлийн шалгуур болгон хэрэгжүүлэх																					
II Стратегийн зорилт: ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙГ ШИНЭЧЛЭН ТОДОРХОЙЛЖ, СУДАЛГАА БОЛОВСРУУЛАЛТЫН АЖЛЫН ҮР ДҮНГ НИЙГЭМД ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ																					
2.1. Шинжлэх ухаан, технологи, инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлж хэрэгжүүлэх																					

2.2. Онолын судалгааны түвшнийг дээшлүүлж, шинэ мэдлэг бий болгох үйл явцыг дэмжих																				
2.3. Хэрэглээний судалгааны чанарыг сайжруулж, тэргүүлэх чиглэлээр шинэ технологи хөгжүүлэх																				
2.4. Монгол Улсын хөгжлийн бодлого тодорхойлох, хэрэгжүүлэхэд манлайлан оролцох																				
2.5. Хүүхэд, залуучуудын шинжлэх ухааны сэтгэлгээг төлөвшүүлэх зорилтыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх																				
2.6. Монголын шинжлэх ухааны ололтыг түгээн сурталчлах зорилтыг дотоод, гадаадын шинжлэх ухаан, боловсролын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх																				
2.7. ШУА-ийн харьяа байгууллагуудаас эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийн хэвлэлийн чанарыг олон улсын жишигт хүргэх, хөгжүүлэх																				
2.8. Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны бүтээлийн чанарыг сайжруулж, импакт фактор бүхий сэтгүүлд нийтлүүлэх бүтээлийн тоог нэмэгдүүлэх																				

III Стратегийн зорилт: ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЖ, ХӨДӨЛМӨРИЙН ҮНЭЛЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ																						
3.1. ”Чадварлаг эрдэмтэн” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх																						
3.2. Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны мэдлэг, чадвар, бүтээлийг үнэлэх шалгуурыг шинэчлэн тогтоож, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх																						
3.3. Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны ажиллаж, амьдрах нөхцөл хангамжийг сайжруулах																						
3.4. Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх																						
IV Стратегийн зорилт: СУДАЛГАА БОЛОВСРУУЛАЛТЫН ТААТАЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ																						
4.1. Олон улсын стандартад нийцүүлэн лабораторийн баазыг бэхжүүлэх																						
4.2. Шинжлэх ухаан технологийн хамтарсан парк байгуулан хөгжүүлэх																						
4.3. Орчин үеийн шаардлагад нийцсэн эрдэм шинжилгээний номын сантай болох																						
4.4. Мэдээллийн технологийн орчин үеийн дэвшлийг судалгаанд хэрэглэх дэд бүтцийн сүлжээ бүрдүүлэн хөгжүүлэх																						

4.5. Хүрээлэнгүүдийн барилга, байгууламжийг шинэчлэх, өргөтгөх																					
V Стратегийн зорилт: ОЛОН ЭХ ҮҮСВЭРТЭЙ САНХҮҮЖИЛТИЙН ТОГТООЦООГ ХӨГЖҮҮЛЭХ																					
5.1. Олон эх үүсвэртэй санхүүжилтийн тогтолцоонд шилжих эрх зүйн орчныг бүрдүүлэх																					
5.2. Шинжлэх ухаан, технологийн салбарын төсвийн санхүүжилтийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн нэмэгдсэн хэмжээнд дүйцүүлж ШУА-ийн санхүүжилтийн хэмжээг өсгөх																					
5.3. Хүрээлэн-хувийн хэвшлийн түншлэлийг өргөтгөж, судалгаа, боловсруулалт, инновацийн үйл ажиллагааг дэмжин санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх																					
5.4. Томоохон зорилтыг шийдвэрлэхэд гадаадын төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг төвлөрүүлэх																					
VI Стратегийн зорилт: ИННОВАЦИЙН ОРЧИН, СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЖ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ																					
6.1. Судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах инновацийн тогтолцоог байгууллагын түвшинд бүрдүүлэх																					
6.2. ”Энтрепренёр эрдэмтэн ” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх																					

6.3.Оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг сайжруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах																				
6.4. Институци хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг хамтран шийдвэрлэх																				
VII Стратегийн зорилт: ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЦАР ХҮРЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ																				
7.1. Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын урьдчилсан бэлтгэлийг хангах, хэрэгжүүлэх зорилтод гадаад хамтын ажиллагааг төвлөрүүлэх																				
7.2. Шинжлэх ухаан, технологи, инновацийн чиглэлээр олон улсын байгууллагуудтай хийх гишүүнчлэлээ нэмэгдүүлж үйл ажиллагаагаа өргөжүүлэх																				
7.3. Олон улсын байгууллагатай хамтран ажиллах бодлого зохицуулалтын үйл ажиллагааг оновчлон, төсөл хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх																				
7.4. Уламжлалт харилцаатай БНХАУ, ОХУ болон бусад орны шинжлэх ухааны болон дээд боловсролын байгууллагатай бүс нутгийн хөгжлийн тулгамдсан асуудлаар шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааг өргөжүүлэх																				

7.5. Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтныг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх чиглэлээр олон улсын нэр хүндтэй их сургууль, шинжлэх ухааны байгууллагатай хамтарсан бодлого боловсруулж хэрэгжүүлэх																					

- *Үндсэн хэрэгжүүлэгч*

- *Хамтран хэрэгжүүлэгч*

- *Туслан хэрэгжүүлэгч*

VI. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГӨ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

№	Үйл ажиллагааны зорилтууд	Шаардлагатай хөрөнгийн хэмжээ (сая төг.)	Үүнээс санхүүжилтийн эх үүсвэр (%)			
			Улсын төсөв	Судалгаа, гэрээт ажлын орлого	Гадаадын төсөл, хөтөлбөр	Бусад
I Стратегийн зорилт: ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ						
1	1.1.Эрх зүйн орчныг шинэчлэн бүрдүүлж, үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлэх	100.0	100	-	-	-
2	1.2.Менежментийн чадавхад суурилсан үр ашиг бүхий бүтэц, зохион байгуулалтыг бүрдүүлэх	50.0	100	-	-	-
3	1.3.Ажлын чанарын үнэлгээний стандартыг байгууллагын хөгжлийн шалгуур болгон хэрэгжүүлэх	-	-	-	-	-
	Дэд дүн	**150.0**				
II Стратегийн зорилт: ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙГ ШИНЭЧЛЭН ТОДОРХОЙЛЖ, СУДАЛГАА БОЛОВСРУУЛАЛТЫН АЖЛЫН ҮР ДҮНГ НИЙГЭМД ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ						
1	2.1. Шинжлэх ухаан, технологи, инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлж хэрэгжүүлэх	30.0	100			
2	2.2. Онолын судалгааны түвшнийг дээшлүүлж, шинэ мэдлэг бий болгох үйл явцыг дэмжих	500.0	40	20	20	20
3	2.3. Хэрэглээний судалгааны чанар, үр өгөөжийг сайжруулж, тэргүүлэх чиглэлээр шинэ технологи хөгжүүлэх	10,000.0	80	-	-	20
4	2.4. Монгол Улсын хөгжлийн бодлого тодорхойлох, хэрэгжүүлэхэд манлайлан оролцох	400.0	50	10	-	40

5	2.5. Хүүхэд, залуучуудын шинжлэх ухааны сэтгэлгээг төлөвшүүлэх зорилтыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	100.0	-	100.0	-	-
6	2.6. Монголын шинжлэх ухааны ололтыг түгээн сурталчлах зорилтыг дотоод, гадаадын шинжлэх ухаан, боловсролын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх	300.0	60	10	10	20
7	2.7. ШУА-ийн харьяа байгууллагуудаас эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийн хэвлэлийн чанарыг олон улсын жишигт хүргэх, хөгжүүлэх	100.0	-	20	-	80
8	2.8. Эрдэм шинжилгээний ажилтнуудын бүтээлийн чанарыг сайжруулж, импакт фактор бүхий сэтгүүлд нийтлүүлэх бүтээлийн тоог нэмэгдүүлэх	-	-	-	-	-
	Дэд дүн	**16,130.0**				
	III Стратегийн зорилт: ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЖ, ХӨДӨЛМӨРИЙН ҮНЭЛЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ					
1	3.1.”Чадварлаг эрдэмтэн” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	1,000.0	40	10	20	30
2	3.2. Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны мэдлэг, чадвар, бүтээлийг үнэлэх шалгуурыг шинэчлэн тогтоож, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх	200.0	50	10	20	20
3	3.3. Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны ажиллаж, амьдрах нөхцөл хангамжийг сайжруулах	5,000.0	10	10	-	80
4	3.4. Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх	-	-	-	-	-
	Дэд дүн	**6,200.0**				
	IV Стратегийн зорилт: СУДАЛГАА БОЛОВСРУУЛАЛТЫН АЖЛЫН ТААТАЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ					
1	4.1. Лабораторийн баазыг олон улсын жишигт нийцүүлэн бэхжүүлэх	30,000.0	60	10	-	30
2	4.2. Шинжлэх ухаан технологийн хамтарсан парк байгуулан хөгжүүлэх	300,000.0	20	-	-	80

3	4.3. Орчин үеийн шаардлагад нийцсэн эрдэм шинжилгээний номын сантай болох	20,000.0	60	-	-	40
4	4.4. Мэдээллийн технологийн орчин үеийн дэвшлийг судалгаанд хэрэглэх дэд бүтцийн сүлжээ бүрдүүлэн хөгжүүлэх	500.0	100	-	-	-
5	4.5. Хүрээлэнгүүдийн барилга, байгууламжийг шинэчлэх, өргөтгөх	10,000.0	100	-	-	-
	Дэд дүн	**360,500.0**				
	V Стратегийн зорилт: ОЛОН ЭХ ҮҮСВЭР БҮХИЙ САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХ					
1	5.1. Олон эх үүсвэр бүхий санхүүжилтийн тогтолцоонд шилжих эрх зүйн орчныг бүрдүүлэх	-	-	-	-	-
2	5.2. Шинжлэх ухаан, технологийн салбарын төсвийн санхүүжилтийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн нэмэгдсэн хэмжээнд дүйцүүлж ШУА-ийн санхүүжилтийн хэмжээг өсгөх	-	-	-	-	-
3	5.3. Хүрээлэн-хувийн хэвшлийн түншлэлийг өргөтгөж, судалгаа, боловсруулалт, инновацийн үйл ажиллагааг дэмжин санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх	1,000.0	70	-	10	20
4	5.4. Томоохон санхүүжилт бүхий зорилтыг шийдвэрлэхэд гадаадын төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг төвлөрүүлэх	200.0	30	-	-	70
	Дэд дүн	**1,200.0**				
	VI Стратегийн зорилт: ИННОВАЦИЙН ОРЧИН, СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЖ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ					
1	6.1. Судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах инновацийн тогтолцоог байгууллагын түвшинд бүрдүүлэх	500.0	50	10	10	30
2	6.2. ”Энтрепренёр эрдэмтэн ” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	100.0	-	20	-	80

3	6.3. Оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг сайжруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах	5,000.0	80	10	-	10
4	6.4. Институци хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг хамтран шийдвэрлэх	100.0	-	-	-	100
	Дэд дүн	**1000.0**				
	VII Стратегийн зорилт: ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЦАР ХҮРЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ					
1	7.1. Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын урьдчилсан бэлтгэлийг хангах, хэрэгжүүлэх зорилтод гадаад хамтын ажиллагааг төвлөрүүлэх	1,200.0	30	10	50	10
2	7.2. Олон улсын байгууллагатай хамтран ажиллах бодлого зохицуулалтын үйл ажиллагааг оновчлон, төсөл хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх	300.0	50	10	10	30
3	7.3. Гадаадын шинжлэх ухааны болон дээд боловсролын байгууллагатай тодорхой чиглэсэн зорилготой хамтарсан судалгааны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, санхүүжилт, хүний болон дэд бүтцийн нөөцийг бэхжүүлэх	3,000.0	20	-	70	10
4	7.4. Уламжлалт харилцаатай БНХАУ, ОХУ, бүс нутгийн бусад орны шинжлэх ухааны болон дээд боловсролын байгууллагатай бүс нутгийн хөгжлийн тулгамдсан асуудлаар шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааг өргөжүүлэх	3,000.0	20	-	70	10
5	7.5. Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтныг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх чиглэлээр олон улсын нэр хүндтэй их сургууль, шинжлэх ухааны байгууллагатай хамтарсан бодлого боловсруулж хэрэгжүүлэх	500.0		40	40	20
	Дэд дүн	**8,000.0**				
	НИЙТ ДҮН	**393,130.0**				

ДОЛООДУГААР БҮЛЭГ

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

7.1. Эрдэм шинжилгээний ажилтныг бэлтгэх, чадавхийг нь бэхжүүлэх

- ✓ Байнга хувьсан өөрчлөгдөж буй орчин, шинжлэх ухаан технологийн ирээдүйн чиг хандлагаас эрдэм шинжилгээний ажилтан бүр хоцролгүй өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх зарчмыг баримтлан энэхүү стратеги төлөвлөгөөний 3.1-д заасан “Чадварлаг эрдэмтэн” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, эрдэм шинжилгээний ажилтныг бэлтгэх, тэдний ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- ✓ Судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг олон улсын жишгээр үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, эрдэм шинжилгээний ажилтны хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлнэ.

7.2. Судалгаа, боловсруулалтын ажлын менежментийг сайжруулах

Улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийн тулгамдсан асуудал, эрэлт хэрэгцээ болон дэлхийн шинжлэх ухаан, технологийн чиг хандлагад нийцүүлэн шинжлэх ухаан технологи, инновацын тэргүүлэх чиглэлийг БСШУСЯ болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд дараах зорилтуудыг шийдвэрлэнэ. Үүнд:

- ✓ Монгол Улсын тогтвортой хөгжлийн бодлогын шинжлэх ухааны үндэслэл боловсруулахад бүх салбарын эрдэм шинжилгээний ажилтны эрдэм, оюуны нөөцийг төвлөрүүлэн зохион байгуулах;
- ✓ Янз бүрийн чиглэлээр хийгдэж буй судалгаа боловсруулалтын ажлуудын уялдаа холбоог зохицуулах механизм бүрдүүлж, эдийн засгийн үндэслэлийг сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэхэд эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтны хамтын ажиллагаа, оролцоог нэмэгдүүлэх;
- ✓ Харьяа хүрээлэнгүүд болон их, дээд сургуулиудын эрдэм шинжилгээний ажилтан нар хамтарч судалгааны төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх арга хэлбэрийг боловсронгуй болгох;
- ✓ Судалгааны орчин үеийн арга зүй болон мэдээлэл технологийн дэвшил, түүний хэрэглээний талаар эрдэм шинжилгээний ажилтны дунд сургалт явуулах;
- ✓ Бүх салбарын хөгжлийн статистик мэдээ болон урьд өмнө хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлын үр дүнгээр тогтмол ажиллагаатай мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, эргэлтэнд оруулах.

7.3. Нийгэм-эдийн засгийн хөгжилд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх

- ✓ Монгол Улсын төр, засгаас хөгжлийн дунд болон урт хугацаанд хэрэгжүүлэхээр шинээр боловсруулах болон өмнө батлан мөрдөн ажиллаж буй хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд эрдэм шинжилгээний ажилтныг өргөн оролцуулж, дэвшүүлсэн гол зорилтуудыг хэрэгжүүлэхэд энэхүү стратеги төлөвлөгөөнй хүрээнд гүйцэтгэх судалгаа боловсруулалтын ажлыг уялдуулан зохион байгуулна.
- ✓ Яам, агентлагууд болон орон нутгийн төр захиргааны байгууллагуудтай гэрээ

байгуулан бодлогын судалгаа хийх, судалгааны ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллана.

- ✓ Шинжлэх ухааны байгууллага- хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, аж ахуйн нэгжүүдийн захиалгат судалгаа боловсруулалтын ажлын цар хүрээг тэлж, санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

7.4. Гадаад хамтын ажиллагааны нөөц боломжийг ашиглах

Стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд дараах арга хэлбэрээр гадаад хамтын ажиллагааг чиглүүлж ажиллана. Үүнд:

- ✓ Засгийн газрын шугамаар гадаад орон, олон улсын байгууллагын зүгээс Монгол Улсад үзүүлж байгаа зээл, тусламжийн хүрээнд хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн судалгааны хэсэгт оролцож, идэвхтэй хамтран ажиллана.
- ✓ Бүс нутгийн нийгэм эдийн засгийн хөгжил, технологи, байгаль орчны асуудлаар хоёр талын (Монгол-Орос, Монгол-Хятад, Монгол-Япон, Монгол-Солонгос, Монгол-Герман гэх мэт) хамтарсан судалгааны баг бүрдүүлж, төсөл хэрэгжүүлнэ.
- ✓ Энэхүү Стратеги төлөвлөгөөний VII зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээнүүдийг хүний нөөцийг хөгжүүлэх, лабораторийн баазыг бэхжүүлэхэд чиглүүлнэ.

7.5. Үйл ажиллагааны төлөвлөлт, удирдлагыг бэхжүүлэх

- ✓ ШУА болон харьяа хүрээлэн, байгууллагуудын жилийн төлөвлөгөө, төсвийн төслийг Стратеги төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулна.
- ✓ Стратеги төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан байгууллагын дотоодод мөрдөх дүрэм, журам, стандартуудыг шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллана.
- ✓ Стратеги төлөвлөгөөний зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор оролцогч, дэмжигч, сонирхогч талуудтай түншийн холбоо тогтоож, харилцан ашигтай хамтран ажиллах, парламентад шинжлэх ухааны лобби бүлэг байгуулах зэрэг арга хэлбэрийг хэрэглэнэ.
- ✓ Академийн санхүүгийн нөөц чадавхийг бэхжүүлэх зорилгоор Шинжлэх ухаан, инновацын хөгжлийг дэмжих сан байгуулж, түүнд гадаад, дотоодын зээл, тусламжийн болон хандив дэмжлэгийн хөрөнгийг төвлөрүүлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Стратеги төлөвлөгөөний үйл ажиллагааны зорилтууд	Хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь түвшин (2018)	Хүрэх түвшин	
					I үе шат	II үе шат
Нэг. Шинжлэх Ухааны Академийн менежментийн чадавхыг бэхжүүлэх:						
1	1.1. Эрх зүйн орчныг шинэчлэн бүрдүүлж, үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлэх	Хууль эрх зүйн актууд *Хууль, УИХ,* ЗГ-ын тогтоол болон сайдын тушаал, ШУА-ийн Их чуулган, Тэргүүлэгчдийн хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн тушаалаар батлагддаг дүрэм журам\	%	80	94	100
		Хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулсан байгууллагын тоо	тоо	10	15	20
2	1.2. Менежментийн чадавхад суурилсан үр ашиг бүхий бүтэц, зохион байгуулалтыг бүрдүүлэх	Бүтэц, зохион байгуулалтын оновчтой хэлбэр	%	70	88	100
3	1.3. Ажлын чанарын үнэлгээний стандартыг байгууллагын хөгжлийн шалгуур болгон хэрэгжүүлэх	Үр дүнд суурилсан ажлын үнэлгээний шинэ стандарт, шалгуур үзүүлэлт	%	30	65	100
Хоёр. Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлж, судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг нийгэмд түгээн дэлгэрүүлэх:						
1	2.1. Шинжлэх ухаан, технологи, инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлж хэрэгжүүлэх	Дэлхийн чиг хандлагыг дагасан тэргүүлэх чиглэлээр хэрэгжсэн төслийн тоо	Тоо	152	218	280
		Үндэсний, үр өгөөжтэй инновацийн хөтөлбөрөөр хэрэгжсэн төслийн тоо	Тоо	5	8	11

2	2.2. Онолын судалгааны түвшнийг дээшлүүлж, шинэ мэдлэг бий болгох үйл явцыг дэмжих	ШУТ сангаас авсан төслийн санхүүжилтийн хэмжээ	Сая төг	1763.87	2000.0	2200.0
3	2.3.Хэрэглээний судалгааны чанарыг сайжруулж, тэргүүлэх чиглэлээр шинэ технологи хөгжүүлэх	Нутагшуулсан технологийн тоо	Тоо	4	6	8
4	2.4. Монгол Улсын хөгжлийн бодлого тодорхойлох, хэрэгжүүлэхэд манлайлан оролцох	Боловсруулсан хөгжлийн бодлого, үзэл баримтлалын тоо	Тоо	5	10	15
5	2.5. Оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг сайжруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах	Патентын мэдүүлгийн тоо	Тоо	10	30	50
		Батлагдсан оюуны өмчийн тоо	Тоо	2	10	30
		Байгууллагын оюуны өмч болон инновацын харилцааг зохицуулах эрх зүйн баримт бичиг бүрдсэн байх	Тоо	-	1	1
		Хамтын ажиллагааны гэрээтэй оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөллийн үйлчилгээ үзүүлэгчтэй эсэх	Тоо	1	3	5
6	2.6. Институци хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг хамтран шийдвэрлэх	Нийт бүтээгдэхүүнд эзлэх инновацийн бүтээгдэхүүн	%	10	20	30
		Шинжлэх ухаан технологийн ололт, инновацийн үйл ажиллагаанаас орох орлогын нийт хөрөнгө оруулалт дахь эзлэх хувь	%	5	10	15
7	2.7. Эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийн чанарыг олон улсын жишигт хүргэх, хөгжүүлэх	Олон улсын жишиг (JPPS стандартыг) хангасан сэтгүүлийн тоо	Тоо	1	4	6
		Импакт фактор бүхий сэтгүүлд нийтлүүлсэн жилийн дундаж өгүүллийн тоо	Тоо	50	100	200

8	2.8. Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны бүтээлийн чанарыг сайжруулж, импакт фактор бүхий сэтгүүлд нийтлүүлэх тоог нэмэгдүүлэх	100 эрдэм шинжилгээний ажилтанд ноогдох импакт фактор өндөр бүхий сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлийн тоо (скопусын өгөгдөхүүнээр)	Тоо	5	7	200
		Хэвлүүлсэн 1 бүтээлээс авсан ишлэлийн тоо	Тоо	2.33	3.0	10
Гурав. Хүний нөөцийг хөгжүүлж, хөдөлмөрийн үнэлэмжийг нь дээшлүүлэх:						
1	3.1.”Чадварлаг эрдэмтэн” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	ЭША-ны тоо	Тоо	890	910	950
		ЭША-ны дундаж нас	Нас	41	39	39
		35-50 хүртэлх насны ЭША-ны эзлэх хувь	%	31	40	45
		Доктор болон түүнээс дээш зэрэгтэй ЭША-ны эзлэх хувь	%	36	40	44
		“Зочин профессор”-ийн тоо	Тоо/ жил	10	20	30
		Олон улсын болон үндэсний судалгааны грант бүхий төсөл удирддаг эрдэмтдийн тоо	Тоо	59/81	70/90	80/100
2	3.2. Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны мэдлэг, чадвар, бүтээлийг үнэлэх шалгуурыг шинэчлэн тогтоож, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх	Үнэлгээний шалгууртай болж, ажилтнуудын дундаж цалин хөлс, урамшуулал өссөн байх	мян.төг	700	1000	1500
		Урамшуулал олгодог хүрээлэнгийн тоо	Тоо	0	5	10
		ОУ-ын томоохон хуралд оролцох санхүүжилтийн хөшүүрэг бий болгох	Тоо	0	0	10
3	3.3. Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны ажиллаж, амьдрах нөхцөл хангамжийг сайжруулах	Ажилтнуудын байр сууцны хангамжийн түвшин, байгууллагын захиалгын орон сууцанд хамрагдсан ЭША-ны тоо	%	50	55	70
			Тоо	-	-	300

4	3.4. Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх	Ёс зүйн дүрэм шинэчлэгдэн батлагдаж хэрэгжсэн байх	%	80	90	100
Дөрөв. Судалгаа боловсруулалтын таатай орчин бүрдүүлэн хөгжүүлэх:						
1	4.1. Олон улсын стандартад нийцүүлэн лабораторийн баазыг бэхжүүлэх	Шинээр байгуулсан лабораторийн тоо	Тоо	-	2	4
		Магадлан итгэмжлэгдсэн лабораторийн тоо	Тоо	-	2	4
		Шинэчлэн тохижуулсан лабораторийн тоо	Тоо	-	5	10
		Дундын лабораторийн тоо	Тоо	0	1	2
2	4.2. Шинжлэх ухааны хамтарсан парк байгуулан хөгжүүлэх	Парк байгуулагдсан байх	Тоо	-	1	1
2	4.3. Орчин үеийн шаардлагад нийцсэн эрдэм шинжилгээний номын сантай болох	Цахим номын сан байгуулагдсан байх	Тоо	-	1	1
3	4.4. Мэдээллийн технологийн орчин үеийн дэвшлийг судалгаанд хэрэглэх дэд бүтцийн сүлжээ бүрдүүлэн хөгжүүлэх	Судалгааны их өгөгдөхүүний төв байгуулагдсан байх	Тоо	-	1	1
4	4.5.Хүрээлэнгүүдийн барилга, байгууламжийг шинэчлэх, өргөтгөх	Шинээр баригдах болон өргөтгөх барилга, байгууламжийн тоо	Тоо	1	3	4
Тав. Олон эх үүсвэр бүхий санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх:						
1	5.1. Олон эх үүсвэр бүхий санхүүжилтийн тогтолцоонд шилжих эрх зүйн орчныг бүрдүүлэх	Шинжлэх ухааны байгууллагын санхүүгийн бие даасан байдлыг өргөжүүлэхтэй холбоотой хууль, эрхзүйн орчинд хийгдсэн өөрчлөлт	тоо	2	3	5
2	5.2. Шинжлэх ухаан, технологийн салбарын төсвийн санхүүжилтийн ДНБ-д эзлэх хэмжээг өсгөх	Салбарын санхүүжилтийн өсөлт, ДНБ-д эзлэх хувь хэмжээ	%	0.12	0.7	1.5
		ШУА-ийн тухайн жилийн Санхүүжилтийн хэмжээ	сая,төг	14,154	20,500	25,000

3	5.3. Хүрээлэн-хувийн хэвшлийн түншлэлийг өргөтгөж, судалгаа, боловсруулалт, инновацийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх	Хамтын ажиллагааны хүрээнд хийгдсэн ажлын тоо, санхүүжилтийн хэмжээ	%	0.02	1	2
4	5.4. Томоохон зорилтыг шийдвэрлэхэд гадаадын төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг төвлөрүүлэх	Гадаадын төсөл, хөтөлбөрөөр санхүүжүүлсэн төслийн тоо	тоо	53	80	100
Зургаа. Инновацийн орчин, соёлыг төлөвшүүлж, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх:						
1	6.1. Судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах, инновацийг хэрэгжүүлэх үүрэг бүхий инновацийн тогтолцоог байгууллагын түвшинд бүрдүүлэн ажиллуулах	Инновац хөгжлийн төв байгуулсан байх	тоо	0	0	1
		Дундын оффис байгуулсан байх	Тоо	0	1	2
		Лицензийн тоо	Сая төг	0	6	12
		Борлуулсан инновацийн бүтээгдэхүүн, технологийн орлогын хэмжээ	Тоо	0	20	60
2	6.2. ”Энтрепренёр эрдэмтэн ” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	Энтрепренёр эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтны тоо	Тоо	7	21	30
		Энтрепренёр эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтанд зориулсан сургалтын тоо	Тоо	2	16	32
		Сургалтанд оролцсон эрдэм шинжилгээний ажилтны тоо	Тоо	54	75	100
		Эрдэм шинжилгээний ажилтанд зориулсан танилцах арга хэмжээний тоо	Тоо	1	8	12
		Энтрепренёр эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны оролцсон, хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо	Тоо	7	10	15

		Энтрепренёр эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны менторын тоо	Тоо	1	5	10
3	6.3. Хүүхэд, залуучуудын шинжлэх ухааны сэтгэлгээг төлөвшүүлэх	Хүүхэд залуучуудын дунд танин мэдэхүйн талаар зохион байгуулсан цуврал лекцийн тоо	Тоо	10	12	14
		Зурагт хуудас, хялбаршуулсан ном		11	14	16
		Кино, богино хэмжээний нэвтрүүлэг		-	2	4
4	6.4. Шинжлэх ухааны ололтыг сурталчлах	Нээлттэй өдөрлөгүүд	Тоо	10	20	30
		Нээлттэй хэлэлцүүлэг, мэтгэлцээний тоо		-	4	4
Долоо. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх:						
1	7.1. Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын урьдчилсан бэлтгэлийг хангах, хэрэгжүүлэх зорилтод гадаад хамтын ажиллагааг төвлөрүүлэх	Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын гол чиглэлээр гадаадын улс оронтой хийсэн гэрээ, санамж бичгийн тоо	Тоо	-	10	16
2	7.2. Шинжлэх ухаан, технологи, инновацийн дэлхий дахины болон бүс нутгийн олон улсын байгууллагын гишүүнээр элсэж, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох	Гишүүнээр элссэн олон улсын байгууллагын тоо	Тоо	10	12	16
3	7.3. Олон улсын байгууллагатай хамтран ажиллах бодлого зохицуулалтын үйл ажиллагааг оновчлон, төсөл хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх	Гадаадтай хамтарсан судалгааны төсөл, хөтөлбөрийн тоо	тоо	56	80	100

4	7.4. Уламжлалт харилцаатай БНХАУ, ОХУ-ын шинжлэх ухааны болон дээд боловсролын байгууллагатай бүс нутгийн хөгжлийн тулгамдсан асуудлаар шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааг өргөжүүлэх	Хоёр болон гурван талт судалгааны төсөл, хөтөлбөрийн тоо	тоо	8	12	16
5	7.5. Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтныг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх чиглэлээр бодлого боловсруулж хэрэгжүүлэх	Гадаадад мэргэжил дээшлүүлсэн ЭША-ны тоо	тоо	46	60	100
		Эрдэмтэн солилцооны хөтөлбөрт хамрагдсан ЭША-ийн тоо	тоо	10	20	30

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ УДИРДЛАГА, ҮНЭЛГЭЭ

9.1. Стратеги төлөвлөгөөний удирдлага, зохион байгуулалт

- ✓ Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүргийг ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын дэргэдэх “Стратеги удирдлагын зөвлөл”-ийн зөвлөл (цаашид Зөвлөл гэх) гүйцэтгэнэ.
- ✓ Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Тэргүүлэгчдийн газрын хурлаар хэлэлцэж батална.
- ✓ Зөвлөл нь Стратеги төлөвлөгөөний зорилт, арга хэмжээнүүдийг Академи болон харьяа хүрээлэн, байгууллагуудын жил бүрийн төлөвлөгөө, төсөвт тусгах, хэрэгжилтийг удирдан зохицуулах, явцад нь хяналт тавих, биелэлтийг дүгнэж, жил бүр ШУА-ийн Тэргүүлэгчдийн газарт тайлагнах, санхүүгийн болон бусад нөөцийг зохистой хуваарилах талаар санал, шийдвэрийн төсөл боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- ✓ Стратеги төлөвлөгөөний хүрээнд гүйцэтгэсэн ажлын гол үр дүнг нэгтгэж, жил бүрийн эцэст Шинжлэх Ухааны Академийн тайланд тусгаж, их чуулганаар хэлэлцүүлнэ.

9.2. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ

- ✓ Зөвлөл нь Стратеги төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт бүрийн хэрэгжилтийн явцыг оны эцэст суурь түвшин (2018)-тэй харьцуулан дүгнэнэ.
- ✓ Зөвлөл Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдээс хэрэгжихгүй байгаа эсвэл дутуу хэрэгжиж буй ажлын явц, шалтгаанд үнэлгээ өгч, авах арга хэмжээний санал боловсруулж ШУА-ийн Тэргүүлэгчдийн газарт танилцуулна.

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1.

ШУА-ИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монголын улсын Шинжлэх ухааны Академи нь үндэсний болон олон улсын хэмжээнд танигдсан, удирдлага зохион байгуулалтын уламжлалт тогтолцоо олон жилийн турш тогтвортой үйлчилж байгаа шинжлэх ухааны тэргүүлэх ууган байгууллага юм.

1206 онд их эзэн Чингис хаан Их Монгол улсаа байгуулаад “Цэцдийн зөвлөл”, 1275 онд Хубилай цэцэн хаан “Монголын бичгийн мэргэдийн хүрээлэн”, 1911 онд Богд хаант Монгол Улсын Засгийн газар “Монголыг судлах газар”, 1921 онд Ардын засгийн газар **“Судар бичгийн (**номын**)** хүрээлэн”, 1961 онд БНМАУ-ын Ардын Их Хурал **“Шинжлэх ухааны Академи”**-ийг тус тус байгуулсан түүхийг тохиолдол гэхээсээ илүү зүй тогтол гэж үзэж болохоор байгаа юм.

Монгол улсын үндсэн хуулийн долоо дугаар зүйлийн нэгдүгээрт “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтанд байна” гэсэн байдаг.

Монгол улсын Их Хурлаас 1996 онд баталсан “Монгол улсын Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай” хуулиар ШУА нь тус улсад шинжлэх ухаан, тэргүүний технологийг хөгжүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны төв байгууллага болохыг хуульчлан заасан билээ.

Ийнхүү Монголын эрдмийн байгууллага 800 гаруй жилийн түүхийг туулжээ. Өнөөгийн ШУА-ийн үйл ажиллагааг “Шинжлэх ухаан технологийн тухай” хууль, “ШУА-ийн эрхзүйн байдлын тухай” хууль, тэдгээртэй холбогдон гарсан эрхзүйн бусад актуудаар нэг талаас, төрийн байгууллагын, нөгөө талаас иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллаганы зарчмууд хослон үйлчилдэг байхаар зохицуулжээ.


Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн “Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны удирдлага” хэмээх хоёрдугаар бүлгийн тавдугаар зүйлд Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны удирдлага нь Монгол Улсын Засгийн газар, Шинжлэх ухаан, технологйин үндэсний зөвлөл, Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Монгол Улсын Шинжлэх ухааны Академиас бүрдэнэ гэж заажээ. Уг бүлгийн аравдугаар зүйлд ШУА-ийн статус болон төрийн бус өмчийн академиудын тухай заасан байна.

Шинжлэх Ухааны Академи нь 1961 оноос хойш энэ нэрээрээ нийгэмд Шинжлэх ухааны үйлчилгээ үзүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.



Зураг I-1. Монгол Улсын төрийн бүтцийн үе дэх ШУА-ийн Түүхэн замнал

Монгол Улсын Шинжлэх ухааны Академи нь “ШУА-ийн эрх зүйн байдлын тухай” хуулийн дагуу шинжлэх ухааны салбараар зохион байгуулсан 6 бага чуулган, бүтцийн төрөлжсөн 2 академи болон харьяаллын 16 эрдэм шинжилгээний хүрээлэнтэйгээр эрдэм судлалын ажлаа гүйцэтгэж байна.



Зураг I-2. Монгол улсын Шинжлэх ухааны Академийн бүтцийн зураглал

Шинжлэх ухааны Академийн харьяа эрдэм шинжилгээний арван зургаан хүрээлэнгийн нийт 88 салбар нэгж, судалгааны лабораториуд нь 907 судлаачтай байгаа ба докторын зэрэгтэй 245 ажилтны бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Үүнд:

Байгалийн ухааны чиглэлээр;

- <u>Биологийн хүрээлэн, 1961 оноос:</u> Тус хүрээлэн нь Суурь судалгааны чиглэлийн Хөхтний экологи, Шувуу, шавж судлал, Гидробиологи, Генетикийн лаборатори; Инновац хөгжүүлэлтийн Молекул биологи, Микробиологи, Микробын нийлэгжил, Ургамлын биотехнологи, Загас үржүүлгийн төв гэсэн үндсэн бүтэцтэй ба Сорилын нэгдсэн лабораторитойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн Монгол-Оросын хамтарсан биологийн иж бүрэн экспедицийн Монголын талыг хариуцан ажилладаг.
- <u>Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн, 1974 оноос:</u> Ургамлын аймаг, ангилалзүй, анатоми, физиологи, ургамалжлын экологи болон ургамлын интродукцын чиглэлээр онолын суурь судалгаа хэрэгжүүлдэг нийт 5 лабораторитой. Монгол орны байгалийн нэн ховор, ховор болон ашигт ургамлын генетик нөөцийг хадгалах хамгаалах зориулалт бүхий Ботаникийн цэцэрлэг, мөн

ургамлын урт хугацааны мониторинг судалгаа явуулах зориулалт бүхий 5 судалгааны суурин төвтэй.

- Хими, химийн технологийн хүрээлэн, 1961 оноос: Тус хүрээлэн нь Байгалийн нэгдлийн химийн лаборатори; Багажит шинжилгээний лаборатори; Биохимийн лаборатори; Материал судлал, технологийн лаборатори; Нүүрсний хими-технологийн лаборатори; Органик химийн лаборатори; Органик бус химийн лаборатори; Хүнсний химийн лаборатори; Эрдсийн технологийн лаборатори; Экологийн химийн лаборатори гэсэн судалгааны 10 лаборатори, мөн Захиргаа, менежментийн алба, нийт 11 нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.
- Физик, технологийн хүрээлэн, 1961 оноос: Онол ба Их энергийн физикийн лаборатори, Цацрагийн биофизикийн лаборатори, Функциональ материалын лаборатори, Энергийн Судалгааны Лаборатори, Электроник, фотоникийн лаборатори, Инновац, технологийн лаборатори гэсэн үндсэн 6 лабораторитойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.
- Газарзүй, геоэкологийн хүрээлэн, 1961 оноос: Физик газарзүй, нийгэм эдийн засгийн газарзүй, цэвдэг судлал, газрын нөөц, газар ашиглалт, хөрс судлал, усны нөөц, ус ашиглалт, ойн нөөц, ой хамгаалал, цөлжилтийн судалгаа, газарзүй мэдээллийн систем, зайнаас тандан судлал, хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн менежментийн чиглэлүүдээр эрдэм шинжилгээний 10 салбар, 3 лаборатори, хээрийн туршилт судалгааг явуулдаг Бүрэнтолгой, Элсэнтасархай, Чойр дах цөлжилтийг сааруулах туршилт, судалгаа, Гурванбулаг дахь бэлчээрийг нөхөн сэргээх туршилт судалгаа, Дамбадаржаа дахь мод үржүүлгийн туршилт судалгаа гэсэн 5 судалгааны суурин төв, өндөр уулын бүсийн цаг уурын автомат станцууд, цэвдгийн мониторингийн цооногууд, хур тунадасны изотопын сүлжээ, хөрс, газрын доорх усны мониторингийн цэгүүдтэй.
- Геологийн хүрээлэн, 1966 оноос: Тус хүрээлэн нь геологийн чиглэлээр онолын суурь судалгаа хэрэгжүүлдэг региональ геологи ба тектоники, магматизм ба металлогени, болон мезо-кайнозойн гэсэн 3 салбар, петрографийн болон микропалеонтологийн 2 лабораторийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.
- Палеонтологийн хүрээлэн, 1964 оноос: Тус хүрээлэн нь Палеозоологи; Микропалеонтологи; Палеоботаник; Стратиграфи, седиментологи; Эртний амьтан, ургамлын сан хөмрөг гэсэн 5 салбарын хүрээнд эрдэм шинжилгээ, судалгаа, боловсруулалтын ажлыг гүйцэтгэж байна.
- Одон орон, геофизикийн хүрээлэн, 1957 оноос: Хүрээлэн нь суурь судалгааны Одон орон судлах оргил, Газар хөдлөл судлал, Соронзон судлал, Сансар судлалын төв, Орон нутаг дахь газар хөдлөлтийг бүртгэх салбар гэсэн 5 үндсэн салбарын хүрээнд судалгаа боловсруулалтын ажлыг явуулж байна.
- Математик, тоон технологийн хүрээлэн, 1974 оноос: Хүрээлэн нь математик, симуляци, тооцоолол болон мэдээллийн технологи гэсэн 3 үндсэн салбартай. Мөн тус хүрээлэнд өндөр хүчин чадал бүхий “Тооцоолон бодох төв”-ийг байгуулан ажиллаж байна. Тус хүрээлэн нь Технологи дамжуулалт, бизнес хөгжлийн салбар, Технологи хөгжүүлэлтийн салбар, Менежмент, санхүүгийн алба гэсэн 2 салбар, 1 албатайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийгмийн ухааны чиглэлээр;

- Археологийн хүрээлэн, 1961 оноос: Археологийн судалгаа, Хүрэл, төмрийн үеийн судалгаа, Хүннү эртний түүхийн судалгаа, дундад зууны

үеийн Монголын түүх, Бүс нутаг ба орчин үеийн түүх, угсаатны судлал, Археологийн мэдээллийн сан ба авран хамгаалах салбар, Түүхийн баримт мэдээллийн төв гэсэн суурь судалгааны чиглэлийн нийт 2 төв, 6 салбартайгаар ажиллаж байна.


- Түүх, угсаатны зүйн хүрээлэн, 1961 оноос: Эртний түүхийн салбар, Монголын эзэнт гүрэн, дундад үеийн түүхийн салбар, Ойрх үеийн түүхийн салбар, Нийгэм соёлын хүн судлалын салбар, Угсаатан судлал, биет бус соёлын өвийн төв, Сурвалж судлал, баримт мэдээллийн төв, Академич Б.Ширэндэвийн дурсгалын танхим гэсэн суурь судалгааны чиглэлийн үндсэн дөрвөн салбар, хоёр төвтэй ажиллаж байна.
- Философийн хүрээлэн, 1972 оноос: Философийн салбар, Социологийн салбар, Улс төр, эрх зүйн салбар, Шашин судлалын салбар, Баян-Өлгийн аймаг дахь салбар, Бодлого судлал, улс төрийн эдийн засгийн ухааны салбар, Ёс зүй, сэтгэл судлалын салбар гэсэн 7 үндсэн салбарын хүрээнд судалгаа боловсруулалтын ажил явуулж байна.
- Олон улсын харилцааны хүрээлэн, 1968 оноос: Олон улс судлалын хүрээлэн нь Орос судлалын салбар, Хятад судлалын салбар, Гуравдагч хөрш орон судлалын салбар, Бүс нутаг, олон талт хамтын ажиллагаа судлалын салбар гэсэн үндсэн 4 салбар, Захиргаа, менежментийн албатайгаар эрдэм шинжилгээ, үйл ажиллагаагаа явуулж байна.
- Хэл зохиолын хүрээлэн, 1921 оноос: Хэл шинжлэлийн салбар, Хэрэглээний хэл шинжлэлийн салбар, Харьцуулсан хэл шинжлэлийн салбар, Утга зохиол судлалын салбар, Сурвалж бичиг, төвөд судлалын салбар, Аман зохиол судлалын салбар, “Эх хэл бичгийн сан хөмрөг, лаборатори” гэсэн 7 салбар, “Монголын нууц товчоо судлалын төв”, “Академич Ц.Дамдинсүрэнгийн гэр музей” гэсэн 1 төв, 1 гэр музейтэй нийт 50 ажилтантай эрдэм шинжилгээ, судалгаа боловсруулалтын үйл ажиллагаа явуулж байна.
- Тархи сэтгэл судлалын хүрээлэн 2021 оноос: Тус хүрээлэн нь молекул, системийн нейросайнсын салбар, эмнэлзүйн нейросайнсын салбар, сэтгэл судлалын салбар, салбар дундын трансляц, инновацын төв гэсэн 4 салбар, мөн захиргаа, менежментийн хэлтэс, нийт 5 нэгж 15 орон тоотойгоор төр хувийн хэвшлийн түншлэлийг идэвхжүүлэн ажиллаж байна.

Хавсралт 2.

ШУА-ИЙН ХАРЬЯА ХҮРЭЭЛЭНГҮҮДИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ ТОО, БҮРЭЛДЭХҮҮН


ШУА-ийн харьяа эрдэм шинжилгээний 10 хүрээлэн 2017 оны эцсийн байдлаар нийт 1085 ажиллагсадтайгаас 887 нь эрдэм шинжилгээний ажилтан, үүний дотор 503 эмэгтэй ажиллаж байна. Академич 29, доктор (Sc.D) 33, доктор (Ph.D) 218 ажиллаж байгаа бөгөөд 35 хүртэлх насны залуучууд нийт эрдэм шинжилгээний ажилтны 54.5 хувь, 35-аас 50 насных 34.5 хувийг эзэлж, дундаж нас 40 байна. Нийт эрдэм шинжилгээний ажилтны 34.7 хувь нь доктор болон түүнээс дээш эрдмийн зэрэгтэй байгаа бөгөөд 129 эрдэм шинжилгээний ажилтан докторантурт суралцаж байна.

Нийт ажилчдаас эрдэм шинжилгээний ажилчдын тоо, хүн ам зүйн бүтэц сүүлийн жилүүдэд хэдэн хувийн хэлбэлзлэлтэй явж ирснийг Зураг II-1-4.-д үзүүлэв.




Зураг II-1. Нийт албан хаагчдын дотор эрдэм шинжилгээний ажилтны эзлэх хувь

Монгол улсын хэмжээнд ажиллаж буй 1500 гаруй эрдэм шинжилгээний ажилтнуудын 60 орчим хувь нь манай байгууллагад төвлөрөн ажиллаж байгаа ба үүний 30-аас дээш хувь нь боловсролын докторооос дээш эрдмийн зэрэг цолтой байгаа нь чамлахааргүй үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт жил ирэх бүр дунджаар 1.5%-иар өсч байгаа ба 2025 он гэхэд жилийн дунджаас 2 дахин буюу 3%-иар өссөн байхаар бид удирдлагын бодлого, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.



Зураг II-2. Нийт эрдэм шинжилгээний ажилтны дотор Академич, Доктор (Sc.D) зэрэгтэй ЭША нарын эрдмийн зэргийн эзлэх хувь




Зураг II-3. Нийт эрдэм шинжилгээний ажилтны дотор Доктор (Ph..D), Магистр зэрэгтэй ЭША нарын эрдмийн зэргийн эзлэх хувь

Хавсралт 3.


ШУА-ИЙН ОЛОН УЛСЫН ТҮВШИНД ТАНИГДСАН БҮТЭЭЛ

“Web of Science” индексжсэн сэтгүүлүүдийн мэдээллийн сангаас ШУА-ийн эрдэмтдийн бүтээл хэвлэгдсэн байдлыг тандахад 2000-2018 оны 4 дүгээр сарын байдлаар 797 бүтээл хэвлүүлж олны хүртээл болгосон байх ба 2017 оныг 2000 онтой харьцуулахад 3 дахин, 2008 онтой харьцуулахад бараг 2 дахин өссөн бөгөөд сүүлийн найман жилийн дундажаар жилд 50 орчим тооны бүтээл олон улсын түвшинд хэвлүүлж байна.



Зураг III-1. ШУА-ийн эрдэмтдийн бүтээл олон улсад танигдан хэвлэгдэж буй байдал

*“Web of Science”*индексжсэн сэтгүүлүүдийн мэдээллийн санд орсон байдлаар бүтээлүүдийг ангилалаар нь авч үзвэл Газарзүй шинжлэх ухаан, түүний салбар дундын чиглэлийн болон Хими, Физик, Экологийн чиглэлийн бүтээлүүд зонхилж байна.




Зураг III-2. “Web of Science” индексжсэн сэтгүүлүүдийн хэвлэгдсэн бүтээлүүдийн ангилал

Мөн Скопусын бүртгэлээр Монголын эрдэмтдийн нийт 51 мянга гаруй бүтээлээс ишлэл авсан байгаа ба нэг бүтээлээс дунджаар 86 удаа (h-index) ишлэл авсан байна.


Хавсралт 4.

ШУА-ИЙН ХАРЬЯА ХҮРЭЭЛЭНГҮҮДИЙН САНХҮҮЖИЛТ, СУДАЛГААНЫ ОРЧИН


Шинжлэх ухаан технологийн салбарыг хөгжүүлэх хууль эрх зүйн зохих орчин бүрдсэн хэдий ч төсвөөс олгож буй нийт санхүүжилт нь дотоодын нийт бүтээгдэхүүний 0.17 хувь буюу ойролцоогоор 34.5 тэрбум төгрөг юм. Үүнээс ШУА-ийн хувьд өнгөрсөн найман жилд төсөв 2 дахин нэмэгдсэн бөгөөд 2025 онд дотоодын нийт бүтээгдэхүүн дэх шинжлэх ухаан технологийн арга хэмжээний зардал 1.5 хувьд хүрнэ гэсэн хүлээлттэй байна.



Зураг IV-1. ШУА-ийн төсвийн санхүүжилт найман жилийн хугацаанд




Зураг IV-2. ШУА-ийн төсвийн нийт орлого



Зураг IV-3. ШУА-ийн санхүүжилтэнд ажилчдын цалин, эрдэм шинжилгээний зардлын эзлэх хувь


Хавсралт 5.

ШУА-ИЙН ХАРЬЯА ХҮРЭЭЛЭНГҮҮДИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТНУУДЫН НАСНЫ БАЙДАЛ, САРЫН ДУНДАЖ ЦАЛИН



Зураг V-1. Нийт албан хаагчдын хүн ам зүйн бүтэц, тоогоор

Эрдэм шинжилгээний ажилтнууд Шинжлэх ухааны байгууллагын төрийн үйлчилгээ гэсэн төсвийн санхүүжилтийн цалингийн шатлал ТҮШУ ангилалаар цалинждаг, эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтны цалин 622,000 төгрөг, эрдэм шинжилгээний тэргүүлэгч ажилтны цалин 740,000 төгрөг байна.



Зураг V-2. ШУА-ийн төсвийн санхүүжилт болон түүнээс цалинд ноогдох хэмжээ, төгрөгөөр.

Хавсралт 6.

ШУА-ИЙН ХАРЬЯА ХҮРЭЭЛЭНГҮҮДИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ЛАБОРАТОРИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

ШУА-ийн хэмжээнд 887 эрдэм шинжилгээний ажилтан ажиллаж байгаа ба харьяа хүрээлэнгүүдэд 52 үл хөдлөх хөрөнгө буюу барилга байгууламж байгаагаас дулаан, цэвэр, бохир усны төвлөрсөн системд холбогдсон 14 байр байгууламж бүхий 20850- $м^2$ талбай ашиглагдаж байна. Энэ нь нэг эрдэм шинжилгээний ажилтанд оногдох нэгж талбайд бодвол 19 $м^2$ байгаа нь ажлын байрны зохиостой хэмжээнд байгаа ба зөвхөн ажлын байрны аюулгүй байдал, тусгай нөхцлийн хамгаалалт, тохь дух, барилга байгууламжийн ашиглалтын хугацаа болон дахин сэргээлтийн асуудлыг хөндөхөөр байна.

ШУА -ийн харьяа 10 хүрээлэн эрдэм шинжилгээний үйл ажиллагаа явуулж байгаа ба 68 салбар нэгж, 57 лаборатори ажиллаж байгаагаас хамгийн эрт байгуулагдсан нь Одон орон, Геофизикийн хүрээлэнгийн Астрофизикийн салбар ба 1957 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн Палеонтологи, геологийн хүрээлэн хамгийн залуу салбарыг өнгөрөгч онд байгуулжээ. Эдгээр 68 салбар нэгж, лабораториудаас 20 гаран салбар нэгж нь 50 гаруй жилийн туршлагатай ажиллаж байна.

,

Хавсралт 7.

ШУА-ИЙН ЭРХЭМ ЗОРИЛГЫН НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Олон улсад нэр хүндтэй	- Бүс нутгийн болон олон улсын ижил чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд байр сууриа бэхжүүлсэн байдал
Өрсөлдөх чадвартай	- Бүс нутагт болон үндэсний хэмжээнд эрдэм шинжилгээний ажилтнуудын чадвар болон тэдний бүтээлийн чанарын түвшингээр тэргүүн эгнээд байх
Шинжлэх ухаан технологи	- Шинэ болон нэмэлт мэдлэг, арга бий болгох, хэрэглэхэд чиглэгдсэн судалгаа боловсруулалт, туршилт, зохион бүтээх үйл ажиллагаа
Үндэсний төв байгууллага	- Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх зорилго бүхий төрийн ивээлд үйл ажиллагаа явуулдаг шинжлэх ухааны төв байгууллага

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2018 оны 01 сарын 12 өдөр Дугаар А/04 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

ШУА-ийн Эрхзүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалт, ШУА-ийн дүрмийн 2 дугаар зүйлийн 10-ын "г" дэх хэсгийг үндэслэн, ШУА-ийн 2018 оны ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. ШУА-ийн үйл ажиллагааны дунд хугацааны Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Г.Чулуунбаатар	*Тэргүүн дэд ерөнхийлөгч /Академич/*
Дэд ахлагч:	А.Бакей	*Академич*
Гишүүд:	Н.Бэгз	*Академич*
	С.Нямзагд	*Академич*
	Т.Ган-Эрдэнэ	*Академич*
	Ц.Лхагвасүрэн	*Академич*
	Д.Сангаа	*Академич*
	Ц.Оюунсүрэн	*Академич*
	Б.Авид	*Эрдэмтэн нарийн бичгийн дарга*
	Б.Бат-Эрдэнэ	*Орлогч дарга*
	А.Баярбаатар	*Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга*
	С.Баяннасан	*Эрдэм шинжилгээ, төлөвлөлтийн хэлтсийн дарга*
	Д.Батхуяг	*Инноваци, мэдээллийн хэлтсийн дарга*
	Р.Бандий	*Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга*
	С.Дэмбэрэл	*Одон орон, геофизикийн хүрээлэнгийн захирал*
	Ш.Ариунаа	*Философийн хүрээлэнгийн захирал*
	Т.Алтансувд	*Хүний нөөц, гэрээ, эрхзүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн*
	Б.Сувданцэцэг	*Олон улсын төсөл, хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтэн*
	М.Алтанбагана	*Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн ЭША*
Нарийн бичгийн дарга:	Н.Навчцэцэг	*Шинжлэх ухааны бодлого төлөвлөлт, дотоод хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн*

2. Төлөвлөгөөг энэ оны 3 дугаар сард боловсруулж, 4 дүгээр сард багтаан Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхийг ажлын хэсэг (*Г.Чулуунбаатар*)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ Д.РЭГДЭЛ

:00000591